



МОНГОЛБАНКНЫ ЭДЭЭЭЛЭЛ



Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт - төгрөгийн тогтвортой байдлыг хангахад оршино.

2019 • VII • № 34

**Б.ГАНТУЯА:
"СААРАЛ
ЖАГСААЛТ"-
ААС УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЭХ НЬ
МОНГОЛ УЛСЫН
ӨМНӨ ТОМ СОРИЛТ
БОЛЖ БАЙНА**

**Ж.САЙНХИШИГ:
ТӨВ БАНКНЫ
ХАРААТ БУС
БАЙДЛЫГ
ҮНДСЭН ХУУЛИАР
БАТАЛГААЖУУЛАХ
ШААРДЛАГА,
ҮНДЭСЛЭЛ БИЙ**



ЗӨВХӨН АЛБАН ХЭРЭГЦЭЭНД

МОНГОЛБАНКНЫ
ЭРДЭНЭСИЙН САНГААС:
ҮРЭЭ ТЭВЭРСЭН ЭХИЙН
ХЭЛБЭРТЭЙ БАЙГАЛИЙН ТӨРЦ АЛТ

ТӨВ БАНКНЫ ХАРААТ БУС БАЙДЛЫГ ҮНДСЭН ХУУЛИАР БАТАЛГААЖУУЛАХЫГ МОНГОЛБАНК ДЭМЖИНЭ

"Төрийн мөнгөний бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх, үнийн тогтвортой байдлыг хангах болон санхүүгийн зах зээл, банкны тогтолцооны тогтвортой байдлыг хангах онцгой чиг үүрэг бүхий Төв банкны хараат бусаар ажиллах нөхцөл, баталгааг улам тодотгон бэхжүүлэхийн тулд Үндсэн хуульд тодорхой зохицуулалтууд тусгах шаардлага бий"

Монгол Улсын Ерөнхийлөгч **Х.БАТТУЛГА**

Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл:

19²¹. Монгол Улс төв банктай байна. Төв банк нь хараат бус, бие даасан байгууллага байх бөгөөд Монголбанк гэж нэрлэнэ.

19²². Монголбанк нь төрийн мөнгөний бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх, үнийн тогтвортой байдлыг хангах болон санхүүгийн зах зээл, банкны тогтолцооны тогтвортой байдлыг хангах замаар үндэсний эдийн засгийн тэнцвэртэй хөгжилд дэмжлэг үзүүлж, төрийн эрдэнэсийн санг эрхлэн удирдана.

19²³. Монголбанкны үйл ажиллагааны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.



МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН
ХУУЛЬД ОРУУЛАХ НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТИЙН ТӨСӨЛ

МОНГОЛ УЛСЫН
ҮНДСЭН ХУУЛЬ

2017 он

Онцлох үйл явдал:

ХУУДАС

Монголбанкны Ерөнхийлөгч
ОУВС-ийн Ази номхон далайн
бүс хариуцсан газрын захирал
Чанён Риг хүлээн авч уулзав

4

Ярилцлага:

ХУУДАС

Б.Гантуяа: "Саарал жагсаалт"-аас
урьдчилан сэргийлэх нь
Монгол Улсын өмнө том
сорилт болж байна

6

Асуулт, хариулт:

ХУУДАС

Монголбанкны хэвлэлийн бага
хурлаас (2019.07.25)

11

**Монголбанкны
мэдээлэл:**

ХУУДАС

Монголбанк эхний 7 сард 7.5
тонн алт худалдан авлаа

16

Нийтлэл:

ХУУДАС

Мөнгө угаахтай тэмцэх үү,
саарал жагсаалтад орох уу?

18

Байр суурь:

ХУУДАС

Төв банкны хараат бус байдлыг
хэрхэн баталгаажуулах вэ?

20

**Монголбанк
юу хийдэг вэ?:**

ХУУДАС

Монголбанкаас хэрэгжүүлж
буй аянуудын үр дүн

22

Дэлхийн үйл явдал:

ХУУДАС

Лорд Кейнс ОУВС-д зочилсон нь

25

**Мөнгөн тэмдэгтийн
түүх:**

ХУУДАС

Өлзийт султан
хааны мөнгөн зоос

29

Банкир:

ХУУДАС

Ж.Сайнхишиг: Төв банкны
хараат бус байдлыг Үндсэн
хуулиар баталгаажуулах
шаардлага, үндэслэл бий

30

Судалгаа:

ХУУДАС

Төв банкны хараат бус
байдал: Олон улсын туршлага,
Монголбанкны анхаарах
асуудлууд

34

Санхүүгийн боловсрол:


ХУУДАС

Банкны санхүүгийн
үзүүлэлтүүдийг хэрхэн
ойлгох вэ?

39

Монголбанкны Ерөнхийлөгч ОУВС-ийн Ази номхон далайн бүс хариуцсан газрын захирал Чанён Риг хүлээн авч уулзав

Монголбанкны Ерөнхийлөгч Н.Баяртсайхан газар, хэлтсийн захирлуудын хамт Олон Улсын Валютын Сан /ОУВС/-ийн Ази номхон далайн газрын захирал ноён Чанён Риг хүлээн авч уулзав. Уулзалтын үеэр Монголбанкны Ерөнхийлөгч Н.Баяртсайхан Монгол Улсад зочилж байгаад талархал илэрхийлээд Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдал болон цаашдын сорилтуудын талаар санал солилцлоо. Ноён Чанён Ригийн зүгээс ОУВС-аас Монгол Улстай хамтран хэрэгжүүлж буй хөтөлбөр үр дүнгээ өгч эдийн засгийн тоон үзүүлэлтүүдэд эерэг өөрчлөлт гарч байгааг тэмдэглээд, цаашид хөтөлбөрийг тууштай хэрэгжүүлэхийн тулд дэмжин ажиллахаа илэрхийлэв.



2019 оны 2-р улирлын инфляцийн тайланг танилцуулав



Монголбанкнаас "Инфляцийн тайлан"-гийн 2019 оны 2-р улирлын тайланг санхүүгийн зах зээлийн мэргэжилтн, сэтгүүлч, олон нийтэд зориулж танилцууллаа. Инфляцийн тайлан нь улирал бүр гардаг бөгөөд Төв банкны олон нийттэй харилцах харилцааны гол арга хэрэгслүүдийн нэг юм. Тус тайланд эдийн засгийн гадаад орчны гол өөрчлөлтүүд, дотоод эдийн засагт өрнөсөн үйл явдлууд, цаашдын төлөв байдлын талаарх шинжилгээнүүдийн үр дүнг тоймлодог.

Монгол Улс дахь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоо, түүний үйл ажиллагааг сэдэвт уулзалт болов

"Монгол Улс дахь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоо, түүний үйл ажиллагаа" сэдэвт уулзалтыг шүүхийн байгууллага, хууль сахиулах байгууллага болон санхүүгийн зохицуулагч байгууллагаас хамтран 2019 оны 7 дугаар сарын 4-ний өдөр зохион байгууллаа. Тус уулзалтаар ФАТФ-ын стандарт болон түүний хэрэгжилт, харилцан үнэлгээний тайлангийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл солилцож, цаашдын хамтын ажиллагааг сайжруулах талаар харилцан санал солилцов.



"Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам", "Хөдөлгөөнт банкны үйлчилгээний журам"-д оруулах өөрчлөлтийг олон нийтээс санал авахаар танилцуулав



Арилжааны банкуудын санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг болон Арчин үеийн шинэлэг техник технологид суурилсан бүтээгдэхүүн үйлчилгээний төрлийг нэмэгдүүлэх, сайжруулах, цахим банкны цогц шийдлийг дэмжих зорилгоор "Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам", "Хөдөлгөөнт банкны үйлчилгээний журам"-д өөрчлөлт оруулах тухай Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалын төслийг боловсрууллаа. Энэхүү төсөлд Захиргааны ерөнхий хуулийн 62 дугаар зүйлд заасны дагуу 30 хоногийн турш олон нийтээс санал авахаар mongolbank.mn сайтаар танилцуулав.

Банкны салбарын баруун бүсийн удирдах ажилтны зөвлөгөөн боллоо



“Банкны салбарын баруун бүсийн удирдах ажилтны зөвлөгөөн-2019” 7 дугаар сарын 24-28-нд Баян-Өлгий аймагт амжилттай зохион байгуулагдлаа. Энэ удаагийн зөвлөгөөнийг нээж, Монголбанкны Тэргүүн Дэд Ерөнхийлөгч О.Эрдэмбилэг үг хэлэв. Мөн үндсэн хэлэлцүүлгийн хүрээнд Монголбанкны Төлбөр тооцооны газрын захирал Э.Анар “Финтек”, НУСЗЗГ-ын захирал А.Энхжин “Валютын захын нөхцөл байдал: Монголбанкны оролцоо” сэдвээр илтгэл тавьж, хэлэлцүүлэг өрнүүлэв. Түүнчлэн ХШГ-ын Ахлах хянан шалгагч Б.Галия “Хариуцлагатай харилцагч-хариуцлагатай банк” аяны талаар мэдээлэл хийсэн юм. Зөвлөгөөнд баруун бүсийн аймгууд болох Говь-Алтай, Ховд, Баян-Өлгий, Завхан, Увс аймаг дахь Монголбанкны салбарын төлөөлөл болон арилжааны банкуудын төлөөлөл оролцож, эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал, орон нутаг дахь банк, санхүүгийн салбарын хөгжил, ирээдүйн чиг хандлагын талаар хэлэлцүүлэг өрнүүллээ.

Фитч агентлаг Монгол Улсын зээлжих зэрэглэлийг хэвээр үлдээв

Фитч (Fitch) агентлаг нь 2019 оны 7 дугаар сарын 04-ний өдөр Монгол Улсын i) урт хугацааны зээлжих зэрэглэлийг “В”, төлөвийг “Тогтвортой” хэвээр, ii) богино хугацааны зээлжих зэрэглэлийг “В” хэвээр үлдээсэн байна. Фитч агентлагаас Монгол Улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээг “В” хэвээр үлдээхэд дараах хүчин зүйлс нөлөөлсөн байна. Тодруулбал, эдийн засгийн өсөлтийн тогтвортой төлөв, төсвийн болон засаглалын үзүүлэлтүүд сайжирч, Төсвийн ашиг 2018 онд ДНБ-ий 2.6 хувьд хүрч, батлагдсан төсөв болон Фитч агентлагийн төсөөлсөн дүнгээс давсан, ГВУН өссөн зэрэг нь нөлөөлжээ.



Дэлхийн банк Монгол Улсад 100 сая ам.долларын дэмжлэг үзүүлэхээр боллоо



THE WORLD BANK

Дэлхийн Банкны Гүйцэтгэх захирлуудын зөвлөл Монгол Улс эдийн засгаа дулам тогтворжуулж, цаашид илүү тогтвортой бөгөөд хүртээмжтэй хөгжилд хүрэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор хоёр дахь удаагийн санхүүжилт болох 100 сая ам. долларыг баталлаа. Уг санхүүжилтийг Дэлхийн Банкны Эдийн Засгийн Удирдлагыг Дэмжих хөтөлбөр (ЭЗУДХ) нь цуврал хөтөлбөрийн хүрээнд олгохоор шийдвэрлэсэн байна. 2017 оны 11 дүгээр сард эхний хөтөлбөр (ЭЗУДХ-1) нь батлагдаж байсан ба энэ удаагийн хөтөлбөр (ЭЗУДХ-2) нь өмнөх хөтөлбөрийн үргэлжлэл юм. ЭЗУДХ нь өрийн тогтвортой байдлыг сэргээх, нийгмийн хамгааллын тогтолцоог бэхжүүлэх, өрсөлдөх чадварыг сайжруулахад чиглэсэн Монгол Улсын бодлогын шинэчлэлийг дэмжиж байгаагаа Дэлхийн банк хэвлэлийн мэдэгдэлдээ дурджээ.



Б.ГАНТУЯА: "СААРАЛ ЖАГСААЛТ"-ААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ НЬ МОНГОЛ УЛСЫН ӨМНӨ ТОМ СОРИЛТ БОЛЖ БАЙНА

Монгол Улс 2013 онд Олон улсын санхүүгийн хориг арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллага буюу ФАТФ-ын "саарал жагсаалт"-д орж, улмаар энэхүү жагсаалтаас гарахын тулд мөнгө угаахтай тэмцэх талаар хууль, эрх зүйн орчноо сайжруулах хүрээнд зарим хууль тогтоомжид өөрчлөлт оруулснаар 2014 оны 6 дугаар сард тус жагсаалтаас хасагдаж байсан түүхтэй.

ФАТФ бол мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн хориг арга хэмжээ авдаг байгууллага. ФАТФ-аас гишүүн улс, орнуудын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог боловсронгуй болгоход чиглэсэн 40 зөвлөмж бүхий стандарт гаргаж, түүний хэрэгжилтийг үнэлэх, санхүүгийн хориг арга хэмжээг хэрэгжүүлдэг билээ.

Сүүлийн үед Монгол Улс ФАТФ-ын саарал жагсаалтад орох эрсдэлтэй байгаа талаар ярьж эхэллээ. Тиймээс манай улсын мөнгө угаахтай тэмцэх үйл ажиллагаа, нөхцөл байдал болон ФАТФ-ын зөвлөмжүүдийн талаар Монголбанкны Ерөнхийлөгчийн хуулийн зөвлөх Б.Гантуяатай ярилцлаа.

МОНГОЛ УЛСАД МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ТОГТОЛЦОО, ФАТФ-ЫН ЗӨВЛӨМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АСУУДАЛ ХЭЗЭЭНЭЭС ЯРИГДАЖ ЭХЭЛСЭН ТУХАЙ ЯРИАГАА ЭХЛҮҮЛЬЕ?

Монгол Улс 2004 онд ФАТФ-ын бүс нутаг хариуцсан байгууллага болох мөнгө угаахтай тэмцэх Ази, номхон далайн бүсийн байгууллагын гишүүн улс болж, улмаар 2006 оны 7 дугаар сард Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг баталсан байдаг. Үүнээс хойш энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа өдрөөс өдөрт эрчимжиж байгаа.

2006 онд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Монгол Улсын тогтолцоонд анхны харилцан үнэлгээг хийснээс хойш хоёр дахь удаагийн харилцан

үнэлгээг 2016 онд Ази, номхон далайн бүсийн байгууллагаар дамжуулан хийсэн.

2016 онд хийгдсэн Харилцан үнэлгээгээр ФАТФ-ын 40 зөвлөмжөөс 20 зөвлөмжийн хэрэгжилтэд хангалтгүй, бодит байдал дээрх хууль тогтоомжийн хэрэгжилтийг үнэлэх Үр дүнтэй байдал /Шууд хэрэгжилт/-ын 11 үзүүлэлтээс 11 үзүүлэлтэд хангалтгүй үнэлгээг Монгол Улс авсан. Үүнтэй холбогдуулан 2017 онд Монгол Улсыг Өргөтгөсөн /эрчимтэй/ хяналтад оруулж, хугацаатай үүрэг даалгавар өгсөн. Үүний хэрэгжилтийг ирэх найм, есдүгээр сард болох Ази, номхон далайн бүсийн байгууллагын ээлжит жилийн хурал, ФАТФ-ын Олон улсын хамтын ажиллагааны хяналтын бүлгийн хурлаар хэлэлцэнэ.

Өргөтгөсөн /эрчимтэй/ хяналтын хугацаанд Монгол Улсаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ,

хийсэн ажил нэлээд байгаа, цаашид хийх ажил ч их бий. Тийм ч учраас сүүлийн жилүүдэд хуульд заасан чиг үүргийнхээ хүрээнд цагдаа, тагнуул, авлигатай тэмцэх газар, прокурор, улсын бүртгэл, гааль, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, арилжааны банкууд гэх мэт төрийн болон хувийн хэвшлийн бүхий л байгууллага мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоо, хууль, эрх зүйн орчинг сайжруулах, хэрэгжилтийг хангахад онцгойлон анхаарч, энэ чиглэлээр цөөнгүй ажлууд хийж байгаа.

**ФАТФ-ЫН 40 ЗӨВЛӨМЖ,
ҮР ДҮНТЭЙ БАЙДЛЫН 11
ҮЗҮҮЛЭЛТИЙН ТАЛААР
ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЭЛ
ӨГӨХГҮЙ ЮУ?**

ФАТФ бол Олон улсын санхүүгийн хориг арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллага бөгөөд өнөөдрийн байдлаар өндөр хөгжилтэй 37 улс орон, 2 олон улсын байгууллагыг эгнээндээ багтаасан байгууллага. Энэ байгууллагын зорилго нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон олон улсын санхүүгийн системийн эрүүл, шударга байдалд учирч буй холбогдох бусад аюул эрсдэлтэй тэмцэхэд чиглэсэн хууль эрх зүйн, бодлогын, зохицуулалтын болон үйл ажиллагааны гэх мэт аливаа үр дүнтэй арга хэмжээний талаарх стандартыг тогтоох, үүнийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх юм. Энэ зорилгын хүрээнд ФАТФ-ын 40 зөвлөмж буюу стандарт бий болж, гишүүн орнууд дотоодын хууль тогтоомждоо энэхүү стандартыг тусган дагаж мөрдөж байна.

Харин Үр дүнтэй байдлын буюу шууд хэрэгжилтийн 11 үзүүлэлтийн тухайд ФАТФ аливаа улс орныг

үнэлэхдээ тухайн улсын энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх хүчин чармайлтын үр нөлөө, хууль эрх зүйн орчны бодит байдалд дээрх хэрэгжилтийг энэхүү 11 сэдэвчилсэн шалгуур үзүүлэлтээр дүгнэдэг.

Тэгвэл манай улсын хувьд түрүүн хэлсэнчлэн ФАТФ-ын 40 зөвлөмжөөс 20 зөвлөмжийн хэрэгжилтэд хангалтгүй, Үр дүнтэй байдлын 11 үзүүлэлтээс 11 үзүүлэлтэд хангалтгүй үнэлгээг авсан байгаа.

**МАНАЙ УЛС ХАРИЛЦАН
ҮНЭЛГЭЭГЭЭР ХАНГАЛТГҮЙ
ҮНЭЛГЭЭ АВЧ, ӨРГӨТГӨСӨН
ЭРЧИМТЭЙ ХЯНАЛТАД
БАЙНА. ҮҮНЭЭС ГАРАХ,
ҮНЭЛГЭЭГ АХИУЛАХ
БОЛОМЖ БИДЭНД БИЙ ЮУ,
ЯМАР АРГА ХЭМЖЭЭ АВЧ
БАЙГАА ВЭ ?**

Дэлхийн улс орнууд энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх талаар дунд болон урт хугацааны үндэсний хөтөлбөр, бодлого боловсруулан хэрэгжүүлж, бодлогын болон үйл ажиллагааны түвшинд төрийн болон хувийн хэвшлийн хүрээнд үндэсний тогтолцоог бүрдүүлэн олон улсын хэмжээнд хамтран ажилласаар байна.

Ингэснээр улс орнууд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцээд зогсохгүй өөрсдийн санхүүгийн системийн эрүүл, аюулгүй байдлыг хамгаалснаар ФАТФ-ын хар, саарал жагсаалтад орох эрсдэлээс урьдчилан сэргийлж, олон улсын системд нэвтрэх боломжтой болох юм.

Тийм учраас мөнгө угаах, терроризм, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх, тэдгээрийг санхүүжүүлэх гэх зэрэг эдгээр үндэстэн дамнасан зохион

байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх асуудал нь Монгол Улс төрийн бодлогын түвшинд авч үзэн, анхаарал хандуулах асуудал юм.

Манай улс 2016 онд хийсэн Харилцан үнэлгээнээс хойш нэлээдгүй ажлыг хийж гүйцэтгэсэн. Тухайлбал, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулсан, Эрүүгийн хууль тогтоомжийг шинэчилсэн, эдгээр хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах хүрээнд журам, заавар, аргачлал, гарын авлага гаргасан, сургалт, семинар, соён гэгээрүүлэх ажил зохион байгуулсан, хяналт шалгалтууд хийсэн, дотоодын болон олон улсын түвшин дэх хамтын ажиллагааг өргөжүүлсэн, 15 сарын хугацаанд авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө болон Үндэсний хөтөлбөрийг Засгийн газраас баталж хэрэгжүүлсэн гэх мэт маш олон ажил хийсэн байгаа.

Өнөөдрийн байдлаар өргөтгөсөн эрчимтэй хяналтын хүрээнд хийж гүйцэтгэсэн ажлын дэлгэрэнгүй тайланг Ази, Номхон далайн бүсийн байгууллагад хүргүүлж, хангалтгүй үнэлгээ авсан 20 зөвлөмжөөс 14 зөвлөмжийн үнэлгээг сайжруулах боломжтой гэсэн урьдчилсан хариуг бид аваад байгаа. Энэ бол маш сайн үзүүлэлт төдийгүй энэхүү үнэлгээний үр дүнг сайжруулах талаар боломжит бүхий л арга хэмжээг авч ажилласан байгууллагуудын хүчин чармайлт юм.

Түүнчлэн энд нэг зүйлийг дурдахгүй байж болохгүй. Үнэлгээний баг 2016 онд манай улсад ажиллах явцад Монгол Улс саарал жагсаалт биш, хар



Манай улс 2016 онд хийсэн Харилцан үнэлгээнээс хойш нилээдгүй ажлыг хийж гүйцэтгэсэн. Тухайлбал, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулсан, Эрүүгийн хууль тогтоомжийг шинэчилсэн, эдгээр хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах хүрээнд журам, заавар, аргачлал, гарын авлага гаргасан, сургалт, семинар, соён гэгээрүүлэх ажил зохион байгуулсан...



жагсаалтад орохоор бага үнэлгээ авах эрсдэл байгааг анхааруулж байсан. Өөрөөр хэлбэл, саарал жагсаалтаас ч муу үр дүн гарах боломжтой нөхцөл байдал байсан хэдий ч тухайн үед Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллагуудын зүгээс өөрсдөөс хамаарах боломжит бүхий л арга хэмжээг авч ажилласан төдийгүй, тухайн үед ажлын хэсгийг ахалж ажилласан хүмүүсийн хүчин чармайлт энэ эрсдэлээс Монгол Улсыг хамгаалж чадсан.

Одоо бидэнд Үр дүнтэй байдлын 11 үзүүлэлттэй холбоотойгоор саарал жагсаалтад орох эрсдэл байсаар байгаа. Үүнд өршөөлийн хууль тогтоомж, түүний хэрэгжилт, НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн тогтоолын хэрэгжилт зэрэг маш олон хүчин зүйл нөлөөлсөөр байна.

ТЭГВЭЛ ҮР ДҮНТЭЙ БАЙДЛЫН 11 ҮЗҮҮЛЭЛТИЙГ ХЭРХЭН АХИУЛАХ ВЭ ? БИД ЮУ ХИЙХ ХЭРЭГТЭЙ ВЭ?

Үр дүнтэй байдлын 11 үзүүлэлтийн үнэлгээг ахиулах боломж процедурын хувьд 5 жилд нэг удаа байдгаараа ФАТФ-ын 40 зөвлөмжийн үнэлгээг ахиулах процедураас ялгаатай.

Товчхон хэлэхэд 2022 он хүртэл энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх Монгол Улсын тогтолцоо ажиллаж байгааг бид баримт нотолгоотой харуулах шаардлагатай байгаа. Жишээлбэл, энэ төрлийн гэмт хэрэгтэй холбогдуулан хураасан хөрөнгийн хэмжээ, мөрдөн шалгасан, хянасан, шийдвэрлэсэн хэргийн үзүүлэлт, хяналт шалгалт, илэрсэн зөрчил, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ гэх мэт бодитой ажил хийсэн байх шаардлагатай.

Энэ төрлийн гэмт хэргийн гаралт гэхээсээ илүү энэ төрлийн хэргийг илрүүлсэн, тогтоосон, шалгасан, шийдвэрлэсэн байдал зэрэг нь эдгээр үзүүлэлтийг ахиулахад бодит нөлөөг үзүүлнэ.

ЭНЭ ЖАГСААЛТАД ОРОХГҮЙ БАЙХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХЭД ОНЦГОЙЛОН АНХААРЧ АЖИЛЛАХ НЬ АЛЪ БАЙГУУЛЛАГА ВЭ? ӨӨРӨӨР ХЭЛБЭЛ, ХЭН ЭНЭ АСУУДЛЫГ ХАРИУЦАН АЖИЛЛАЖ, МАНАЙ УЛСЫН ТАЙЛАНГ ХАМГААЛАХ ВЭ?

Хэрэв ФАТФ-ын 40 зөвлөмжийг унших юм бол энэ бол үндэсний хэмжээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ, төрийн бүх байгууллага бүхий л түвшинд ажиллах асуудал гэдгийг ойлгоход нэг их хэцүү биш.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасны дагуу үндэсний хөтөлбөр боловсруулж батлуулах, хэрэгжилтийг хангах арга хэмжээг авах хүрээнд Үндэсний зөвлөл, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, мэдээлэл солилцох, эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх талаар зөвлөмж гаргах хүрээнд Хамтын ажиллагааны зөвлөл ажиллаж байна.

Энэ 2 зөвлөлийн бүрэлдэхүүнд цагдаа, тагнуул, авлигатай тэмцэх байгууллага, прокурор, шүүх, Сангийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Гадаад харилцааны яам, Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, гааль, татвар, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, улсын

бүртгэл, Санхүүгийн мэдээллийн албаны төлөөлөл багтдаг.

Өөрөөр хэлбэл, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог бодит байлгах, хуулийн хэрэгжилтийг хангах, улмаар Монгол Улсыг саарал жагсаалтад орохоос урьдчилан сэргийлэх ажил нь манай улсын үндэсний эдийн засгийн аюулгүй байдалд хамаарах асуудал учраас эдгээр байгууллагуудын хамтын ажил, хамтын хариуцлага юм.

Товчхондоо энэ бол Монгол Улсын хариуцлагын асуудал.

Монголын санхүүгийн зах зээлд банкны салбар давамгайлдаг гэдэг утгаараа зохицуулагч байгууллагын хувьд Монголбанк энэ асуудалд онцгойлон анхаарч, Монгол Улсын тайланг бэлтгэх, хамгаалах бүхий л ажлыг зохион байгуулж, тайланг хамгаалах Ажлын хэсэг, Хамтын ажиллагааны зөвлөлийн ажиллах нөхцөл бололцоог бүхий л талаар дэмжин ажиллаж байгаа. Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллагууд ч сүүлийн жилүүдэд хамтын ажиллагаагаа эрчимтэй өргөжүүлэн ажиллаж байгааг дурдах нь зүйтэй.

**ФАТФ-ЫН СААРАЛ
ЖАГСААЛТАД ОРОХООС
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХИЙН
ТУЛД НЭН ТЭРГҮҮНИЙ АВЧ
ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖИЛ БОЛ
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ, ХАМТЫН
АЖИЛЛАГААНЫ ЗӨВЛӨЛИЙН**

**ГИШҮҮН БАЙГУУЛЛАГУУДЫН
ХАРИУЦЛАГА, ХАМТЫН
АЖИЛЛАГАА ЮМ БАЙНА.
ТЭГВЭЛ ЭНЭ БОГИНО
ХУГАЦААНД ХАМТРАН
АЖИЛЛАХ ХҮРЭЭНД
АЧ ХОЛБОГДОЛ БҮХИЙ
ЯМАР АЖЛУУДЫГ ХИЙХ
БОЛОМЖТОЙ ВЭ?**

2016 онд хийсэн Харилцан үнэлгээнээс хойш Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллагуудын үйл ажиллагаа эрчимжсэн гэдгийг дурдсан. Нэг үеэ бодоход мөнгө угаахтай тэмцэх асуудал бол зөвхөн Санхүүгийн мэдээллийн албаны ажил гэх өрөөсгөл ойлголт харьцангуй өөрчлөгдөөд байгаа.

Энэ бол мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр хийсэн сургалт, семинар, мэдээлэл, хамтын ажлын үр дүн байх. Үүний дүнд байгууллагууд өөрсдийн үүрэг хариуцлагыг ойлгон хамтран ажиллаж эхлээд байгаа. Иймд бидэнд саарал жагсаалтад орохгүй байх бүрэн боломж байгаа гэж харж байна.

Хэдийгээр олон ажил хийж байгаа ч бодлогын түвшинд, хэрэгжилтийн түвшинд гээд хууль тогтоох эрх мэдэл, шүүх эрх мэдэл, гүйцэтгэх эрх мэдлийн бүхий л байгууллагын үйл ажиллагаатай холбоотой яаралтай хийж гүйцэтгэх хэд хэдэн ажил бидэнд бий.

Тухайлбал, УИХ-д өргөн мэдүүлсэн Терроризмтой тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, дагаж гарах хуулийн төслүүдийг УИХ-аар хэлэлцүүлэн батлуулах, Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх, мөрдөн шалгах талаар аргачлал заавар гарган мөрдөж ажиллах, Мөнгө угаах гэмт хэргийг шалгах, эцэслэн шийдвэрлэх ажлыг эрчимжүүлэх, энэ төрлийн гэмт хэргээс олсон хөрөнгө орлогыг хураах, Хөрөнгө хураахад баримтлах үйл ажиллагааны аргачилсан заавар боловсруулах, Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх хүсэлт, гэмт этгээдийг шилжүүлэн авах, шилжүүлэн өгөх хүсэлтийг бүртгэж, хяналт тавих нэгдсэн бүртгэлийг үүсгэх, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхтэй холбоотой статистик мэдээлэл гаргах нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх гэх зэрэг ажлыг бид ойрын хугацаанд авч хэрэгжүүлэх шаардлагатай байгаа.

Ярилцсанд баярлалаа!



САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН АЛБАНЫ ДЭРГЭДЭХ ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮН БАЙГУУЛЛАГУУД



МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

Монголбанк

Сангийн яам

Гадаад харилцааны яам

Хууль зүй, дотоод
хэргийн яам

Шүүхийн ерөнхий зөвлөл

Улсын ерөнхий
прокурорын газар

Санхүүгийн зохицуулах хороо

Тагнуулын ерөнхий газар

Цагдаагийн ерөнхий газар

Авлигатай тэмцэх газар

Гаалийн ерөнхий газар

Татварын ерөнхий газар

Улсын бүртгэлийн ерөнхий
газар

Терроризмтой тэмцэх
ажиллагааг зохицуулах зөвлөл

Монголбанкны дэргэдэх
Санхүүгийн мэдээллийн алба

Дарга

Хууль зүй, дотоод хэргийн сайд

Орлогч
дарга

Тагнуулын ерөнхий газрын дарга

Гишүүд

Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгч

Улсын ерөнхий прокурорын орлогч

Авилгатай тэмцэх газрын дэд дарга

Засгийн газрын хэрэг эрхлэх газрын
Тэргүүн дэд дарга

Сангийн дэд сайд

Гадаад харилцааны дэд сайд

Шүүхийн ерөнхий зөвлөлийн
Гүйцэтгэх нарийн бичгийн дарга

Санхүүгийн зохицуулах хорооны
Дэд дарга

Цагдаагийн ерөнхий газрын
Тэргүүн дэд дарга

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий
газрын Тэргүүн дэд дарга

Гаалийн ерөнхий газрын Дэд дарга

Татварын ерөнхий газрын Дэд дарга

Улсын бүртгэлийн ерөнхий газрын Дэд дарга

Нарийн
бичгийн дарга

Монголбанкны дэргэдэх Санхүүгийн
мэдээллийн албаны дарга



МОНГОЛБАНКНЫ ХЭВЛЭЛИЙН БАГА ХУРЛААС (2019.07.25)

Монголбанкнаас сар тутам зохион байгуулдаг ээлжит хэвлэлийн бага хурал 7 дугаар сарын 25-ны өдөр болж, Монголбанкны газар, хэлтсийн захирлууд цаг үеийн асуудлаар мэдээлэл өгч, сэтгүүлчдийн асуултад хариуллаа.

SBN ТВ:

Өөрийн хөрөнгийг нэмэгдүүлсэн арилжааны банкуудыг Монголбанкнаас зарлах боломжтой юу? Үүнээс гадна дахин нэг арилжааны банк дампуурах гэж байна гэх мэдээлэл олон нийтийн сүлжээгээр яваад байна. Энэ талаар Монголбанк мэдээлэл өгөх боломжтой юу?

ХШГ-ын захирал **Н.БАТСАЙХАН:**

Монголбанкнаас саяхан мэдэгдэл гаргасан. Уг мэдэгдлээр өөрийн хөрөнгөө нэмэгдүүлсэн банкуудын нэрсийг дурдаад тэдгээрийн өөрийн хөрөнгө нэмэгдүүлсэн эх үүсвэрийг шалгаж байгаа тухай дурдсан байгаа. Банк дампуурна гэсэн цуурхал гадуур их явж байна. Одоогоор ямар нэгэн банк дампуураагүй байна. Монголбанк хуулийн дагуу хяналт, шалгалтаа тавин ажиллаж байгаа.

SBN ТВ:

Капитал банкинд байршсан нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг хэрхэн шийдвэрлэж байгаа вэ?

ХШГ-ын захирал **Н.БАТСАЙХАН:**

Монголбанкнаас томилогдсон эрх хүлээн авагч тухайн банкны үлдэгдэл хөрөнгийг зарж, борлуулж

олсон орлогоос нийгмийн даатгалын мөнгийг барагдуулах үүрэгтэй. Энэ талаар нийгмийн даатгалын газар болон бусад байгууллагуудын нэхэмжлэхийг хүлээн авсан. Улмаар холбогдох дарааллыг гаргаад, нэхэмжлэлийг барагдуулж эхэлсэн байгаа.

NTV:

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх чиглэлээр Монгол Улсыг идэвхгүй ажиллаж байна гэж олон улсын байгууллагаас шүүмжилж, саарал жагсаалтад оруулах асуудлыг ярьж байгаа. Хэрвээ саарал жагсаалтад орвол ямар эрсдэл учрах вэ?

СМА-ны дарга **Х.БАТЧУЛУУН:**

Аливаа улс саарал жагсаалтад орсон тохиолдолд бусад харилцагч улсын зүгээс тухайн улсын санхүүгийн системийн үйл ажиллагаанд тавих хяналтаа өндөрсгөнө. Энэ нь юу гэсэн үг вэ гэхээр Монгол руу орж ирж байгаа, эсвэл гарч байгаа аливаа гүйлгээнд тавих хяналт нь нэмэгдэж, илүү их мэдээллийг шаардаж эхэлнэ гэсэн үг. Зарим хэвлэл, мэдээллийн сувгаар дурдсанчлан мөнгө шилжүүлэхээр маш олон зүйл асууж, шаардаад байна гэдэг асуудал илүү чанга явагдана. Яагаад гэвэл саарал жагсаалтад аливаа улс орно гэдэг маань тухайн улс дотооддоо мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэхгүй байна гэсэн дохиог бусад улсад өгч байгаа. Мэдээж бусад улс

орон өөрийн эдийн засаг, санхүүгийн системээ бохир мөнгөнөөс хамгаална. Тийм учраас тухайн саарал жагсаалтад орсон улс орнуудаас ирж байгаа мөнгөн урсгалд тавих хяналтаа чангаруулдаг. Манай улсын хувьд гадаадаас орж ирж байгаа болон гадагшаа гарч буй мөнгөн урсгалд хүндрэл учраад эхэлбэл, манай улсын гадаадын хөрөнгө оруулалтаас эхлээд асуудал үүснэ. Энэ утгаараа саарал жагсаалтад орвол нийт эдийн засагт нэлээд том цохилт болох эрсдэлтэй.

ӨДРИЙН СОНИН:

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх чиглэлээр дотоодын хууль, хүчний байгууллагууд хангалтгүй ажиллаж байгаа тал байгаа юу. Манай улсад энэ чиглэлээр шүүхээс ял шийтгэл авсан тохиолдол огт сонсогдохгүй байгаа нь эргээд үнэлгээнд нөлөөлж байгаа гэсэн. Энэ тал дээр хамтын ажиллагаа хэрхэн хангагдаж байгаа вэ?

СМА-ны дарга **Х.БАТЧУЛУУН:**

Гадны орнуудад мөнгө угаах зүйлчлэлээр нэлээд олон хэрэг шийдэгддэг, ял шийтгэл авдаг. Манай улсад тийм зүйл огт сонсогдохгүй байна. Яагаад вэ гэсэн асуулт гэж ойлголоо. Гадны орнуудад мөнгө угаах чиглэлээр хяналтаа муу хийсэн банкуудыг хэдэн сая, тэрбум доллараар торгож байгаа. Бидний хувьд манай харилцан үнэлгээний тайланг хэлэлцэж байх үед бүх мэдээллийг 2016 оны 10 дугаар сараар таслаад, тэрнээс өмнөх мэдээллүүдэд үндэслэн үнэлгээгээ хийсэн. Тэр үед Монгол Улсад мөнгө угаах чиглэлээр ямар нэгэн ял шийтгэл оноосон тохиолдол гараагүй байсан. Энэ нь үнэлгээ хийж байгаа хүмүүст юуг харуулсан бэ гэхээр “Монгол Улс тогтолцоогоороо мөнгө угаах гэмт хэрэг ямар хор нөлөөтэй вэ гэдгийг ойлгохгүй байна” гэсэн мэдрэмжийг өгсөн байгаа юм. Өнгөрсөн онд дахин үнэлгээгээ хамгаалж байх үед Монгол Улсад мөнгө угаахтай холбоотой 14 хэрэг шүүхийн анхан шатыг давсан байсан. Мэдээж суурь хэрэг нь арай өөр, үүнийг дагаад мөнгө угаах зүйлчлэлтэй хэргүүд шүүхээр шийдэгдсэн байсан. Энэ талаар дэлгэрэнгүй мэдээллийг хууль, шүүхийнхнээс авах хэрэгтэй болов уу. Энэ бол бүхэл бүтэн тогтолцооны асуудал. Нэг байгууллагын асуудал биш гэдгийг энд хэлье.

ӨДРИЙН СОНИН:

Уул уурхай, боловсруулах үйлдвэрлэл хоёр салбар зээлийн үлдэгдэл нэлээд өндөр байгааг статистикаас харлаа. Үүний шалтгаан юу байна вэ?

ССГ-ын захирал **Б.БАТДАВАА:**

Монгол Улсын эдийн засгийн онцлогоос шалгаалж байгаа. Манай эдийн засагт уул уурхай болон боловсруулах салбарын эзлэх жин өндөр. Мөн уул уурхайн идэвхжилтэй холбоотойгоор энэ салбарын зээлжилт өссөн байгаа.

ӨНӨӨДӨР СОНИН:

Ипотекийн зээлийн дундаж хүү 8 хувиас өндөр байгаа нь ямар шалтгаантай вэ. Банкууд өөрсдийн хөрөнгөөр бас давхар ипотекийн зээл олгож байгаа гэсэн үг үү?

НУСЗГ-ын ахлах эдийн засагч **Б.МӨНХЗУЛ:**

Ипотекийн зээлийн санхүүжилтийн хувьд оны эхний хагас жилийн байдлаар Монголбанк, Засгийн газар, банкуудын эх үүсвэрээр нийт 210 тэрбум төгрөгийн санхүүжилтээр 2937 иргэнд ипотекийн зээл олгосон байна. Энэ зээл маань тогтмол хүүтэй олгогдож байгаа. Үүнээс гадна тогтмол хүүтэй бус, ипотекийн хөтөлбөрт хамаарахгүйгээр банкуудын өөрийн эх үүсвэрээс олгож байгаа зээл бий. Үүнээс хамаараад жигнэсэн дундаж хүү өөрчлөгдөх боломжтой юм.

МҮОНТ:

ФАТФ-ын 40 зөвлөмжтэй холбоотойгоор илүү тодорхой мэдээлэл өгөөч. 2017 онд 40 зөвлөмжөөс 20-ыг нь Монгол Улс шаардлага хангахгүй байна гэж байсан. Харин энэ онд дээрх 20-оос 10 гаруй нь боломжийн хангагдаж эхэлсэн гэдгийг ФАТФ-аас мэдээлсэн байна. Үүнд яг ямар чиглэлийн зөвлөмжүүд багтаж байгаа вэ, үнэлгээ хэвийн болоход юу голчлон нөлөөлөх вэ?

СМА-ны дарга **Х.БАТЧУЛУУН:**

1 дүгээр сарын 31-нд бид дагалдах тайлангаа явуулахад 2017 оны харилцан үнэлгээний тайланд муу үнэлгээ авсан бүх зөвлөмжийнхөө үнэлгээг дээшлүүлэх хүсэлтээ илгээсэн. 20 зөвлөмжөөс бид одоогоор 14-ийг нь ахиулах боломжтой байгаа. Энэ бол эцсийн дүн биш л дээ. Манайх наймдугаар сард тайлангаа хамгаална. Хамгаалсны дараа л эцсийн дүн гарна. Наймдугаар сард очиж хамгаалахдаа 14 зөвлөмжөө ахиулахаас гадна өмнө нь сайн үнэлгээ авсан зөвлөмжүүдээ тэр чигээр

нь хадгалах ёстой. Үүний тулд бид идэвхтэй ажиллаж байна. Энэ ажлаа тууштай үргэлжлүүлэх ёстой.

SBN ТВ:

Үндсэн хуулийн өөрчлөлтөд Төв банкны хараат бус байдлыг тусгах талаар яригдаж байгаа. Энэ талаар Монголбанк ямар байр суурьтай байгаа вэ. Төв банкны хараат бус байдлыг Үндсэн хуулийн түвшинд баталгаажуулах зайлшгүй шаардлага бий юу?


ХЭЗГ-ын ЭЗБХ-ийн хэлтсийн захирал **Б.ЭРДЭНЭХУЯГ:**

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгаас УИХ-д өргөн мэдүүлсэн “Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төсөлд “Монгол Улс бие даасан, хараат бус төв банкттай байна. Түүнийг Монголбанк гэж нэрлэнэ” гэж дурдсан. Мөн “Төв банкны үндсэн үйл ажиллагаа нь эдийн засаг, банк, санхүүгийн тогтвортой байдлыг хангах, төрийн эрдэнэсийн санг удирдан явуулах. Төв банкны ажиллах эрх зүйн үндсийг хуулиар тогтооно” гэсэн агуулгатай заалтуудыг тусгасан. Үүнийг


Монголбанкны зүгээс төв банкны хараат бус байдлаар дамжуулан Монгол Улсын эдийн засгийн тогтвортой байдлыг хангах чухал суурь, үндсэн зарчмыг тогтоох алхам болсон гэж харж байгаа. Төв банкны хараат бус байдлыг хангаснаар үнийн тогтвортой байдлаар дамжуулан эдийн засгийн тогтвортой байдлыг бүрдүүлэхэд чухал нөлөөтэй. Энэхүү алхмыг хийснээр цаашид төв банкны удирдлагыг хэрхэн томилох, Засгийн газартай ямар харилцаатай байх вэ гэх зэрэг төв банкны бие даасан байдлын голлох ойлголтуудыг Үндсэн хуулиар баталгаажуулж, зөрчигдсөн тохиолдолд Үндсэн хуулийн Цэц дээр хэлэлцэх юм. Тийм учраас Монголбанкны зүгээс Үндсэн хуулийн өөрчлөлтийн процессыг анхааралтай ажиглаж байна. Мөн олон нийтийн зүгээс ч бас Төв банк хараат бусаар ажиллах тухай Үндсэн хуулийн заалтын ач холбогдлыг ойлгож, дэмжих байх гэж найдаж байна.

1. Мөнгөний үзүүлэлтүүд

Зураг 1.1. Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлтийн бүтэц



Зураг 1.2. Мөнгөний үзүүлэлтүүдийн сарын өөрчлөлт, тэрбум ₮



- M2 мөнгөний жилийн өсөлт **16.6%** -д хүрч **20.2** их наяд ₮-т хүрэв.

- Өмнөх сараас **0.3%**-иар буюу **71** тэрбум ₮-өөр буурав.


Үүнээс **M1** мөнгө **8.1%** (307.6 тэрбум ₮) –иар өсч, **бусад хадгаламж 2.3%** (378.6 тэрбум ₮) –иар буурсан байна.

• **M1** → ₮-ийн харилцах **321.6** тэрбум ₮-өөр өсч, хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө **13.9** тэрбум ₮-өөр буурав.


• **Бусад хадгаламж** → \$-ийн хадгаламж **3.1** тэрбум ₮-өөр өсч, ₮-ийн хадгаламж **349.9** тэрбум ₮-өөр, \$-ийн харилцах **31.8** тэрбум ₮-өөр буурсан байна.

1. Мөнгөний үзүүлэлтүүд

Зураг 1.3. Мөнгөний нийлүүлэлтийн бүтэц




Зураг 1.4. Нийт хадгаламж




- Нийт M2 мөнгөний нийлүүлэлтийн 54.1%-ийг төгрөгийн хадгаламж, 17.1%-ийг төгрөгийн харилцах, 14.5%-ийг валютын хадгаламж, 11.2%-ийг валютын харилцах, үлдсэн 3.2%-ийг хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө бүрдүүлж байна.
- Нийт хадгаламжийн хэмжээ 13.9 их наяд төгрөгт хүрснээс 83%-ийг иргэдийн хадгаламж, 17%-ийг байгууллагын хадгаламж бүрдүүлж байна.
- Иргэдийн хадгаламжийн 20.7%, байгууллагын хадгаламжийн 23.4%-ийг гадаад валютын хадгаламж бүрдүүлж байна.

2. Зээл

Зураг 2.1. Зээлийн үлдэгдлийн жилийн өсөлт, сектороор




Зураг 2.2. Нийт зээл, гадаад валютын эзлэх хувь



- Банкуудын зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 18%-иар өсч 18.1 их наяд төгрөгт,
- Иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл 26%-иар өсч 9.4 их наяд төгрөгт,
- Хувийн байгууллагынх 10%-иар өсч 8.5 их наяд төгрөгт тус тус хүрчээ.
- Нийт зээлийн 14%-ийг, Иргэдийн зээлийн 1.6%-ийг, хувийн байгууллагын зээлийн 27%-ийг гадаад валютын зээл бүрдүүлж байна.

2. Зээл

Зураг 2.5. Хувийн байгууллагын зээлийн үлдэгдэл (салбар бүтэц)



Зураг 2.6. Иргэдийн зээлийн үлдэгдэл (салбарын бүтэц)



- Хувийн байгууллагын зээлийн үлдэгдлийн дийлэнх хувийг худалдаа, барилга, боловсруулах, уул уурхайн салбарын зээл бүрдүүлэв.
- Иргэдийн зээлийн 37%-ийг орон сууцны зээл (МИК-д шилжүүлсэн багцыг оруулснаар), 34%-ийг цалин, тэтгэврийн зээл бүрдүүлэв.

3. Ипотекийн зээл

Зураг 3.1. Тайлант сард олгосон ипотекийн зээл



Тайлант сард банкууд 780 зээлдэгчид 58.3 тэрбум төгрөгийн ипотекийн зээл шинээр олгосноос 46.0% нь хөтөлбөрийн, 54.0% нь банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээл байв.


Зураг 3.2. Тухайн сард олгосон ипотекийн зээлийн хүү




Шинээр олгосон ипотекийн зээлийн жигнэсэн дундаж хүү өмнөх сараас 0.3 нэгж хувиар өссөн бол, өмнөх оны мөн үеэс 0.1 нэгж хувиар буурчээ.

4. Хүү

Зураг 4.1. Нийт шинээр татсан хадгаламж, хүү




Зураг 4.2. Нийт шинээр олгосон зээл, хүү



- Иргэдээс татсан төгрөгийн хадгаламжийн ЖДХ 11.3%, хувийн байгууллагаас татсан төгрөгийн хадгаламжийн ЖДХ 11.0% байна.
- Иргэдэд шинээр олгосон төгрөгийн зээлийн ЖДХ 17.5%, хувийн байгууллагад олгосон төгрөгийн зээлийн ЖДХ 16.7% байна.

5. Гадаад сектор

5.1 Төлбөрийн тэнцлийн статистик, 2019 оны эхний 6 сар



МОНГОЛБАНК ЭХНИЙ 7 САРД 7.5 ТОНН АЛТ ХУДАЛДАН АВЛАА

Монголбанк 2019 оны эхний 7 сард 7.5 тн үнэт металл худалдан авсан нь өмнөх оны мөн үед 9.3 тн үнэт металл худалдан авснаас 1.8 тонноор бага буюу 19%-иар буурсан үзүүлэлттэй байна.

Монголбанк 2019 оны 7 дугаар сард 1.5 тн үнэт металл худалдсан авсан ба үүнээс Дархан-Уул аймаг дахь Монголбанкны хэлтэс 134 кг үнэт металл, Баянхонгор аймаг дахь Монголбанкны салбар 106 кг үнэт металлыг худалдаж авсан нь өмнөх оны мөн үед 2.2 тн үнэт металл худалдан авч байснаас 649 кг-аар буурсан үзүүлэлттэй байна.

2019 оны 7 дугаар сард 1 грамм алт худалдан авах Монголбанкны дундаж үнэ 120,680.95 төгрөг байлаа.



График 1. 2018-2019 онд Монголбанкны худалдан авсан алтны сарын мэдээ (кг)





График 2. 1990-2019 онд Монголбанкны худалдан авсан алтны хэмжээ (тонн)



График 3. 2019 оны 7 дугаар сард Монголбанкны алт худалдан авсан үнэ (төгрөг)

ВАЛЮТ АРИЛЖААНЫ ЦАХИМ ТАЛБАРЫН АРИЛЖААНЫ ТОЙМ

БХВАЦТ-ыг 2017/4/10-нд нэвтрүүлснээс хойш 2019/07/31-ний хооронд 1,296,9 сая ам.долларын болон 113.4 сая юанийн нийт 1166 удаагийн арилжаа БХВАЦТ-т хийгдээд байна.



ИПОТЕКИЙН ЗЭЭЛД 246 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН САНХҮҮЖИЛТ ОЛГОВ

Ипотекийн зээлийн хөтөлбөрийн хүрээнд 2019 оны эхний 7 сарын байдлаар нийт 246 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 3,479 иргэнд олгоод байна. Үүнээс 2019 оны 7 дугаар сард Монголбанкны эх үүсвэрээс 16 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 237 иргэнд, Засгийн газрын эх үүсвэрээс 10 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 165 иргэнд, банкууд өөрийн эх үүсвэрээс нийт 10 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 140 иргэнд тус тус олголоо.



МӨНГӨ УГААХТАЙ ТЭМЦЭХ ҮҮ, СААРАЛ ЖАГСААЛТАД ОРОХ УУ?

Сүүлийн хугацаанд Монгол Улсын эдийн засгийн бараг бүх тоон үзүүлэлтэд ахиц гарч, 2016 оны түвшинтэй харьцуулахад ихээхэн эерэг өөрчлөлтүүд бий болоод байна. Үүнд нэг талаас гадаад орчны таатай нөлөө, хөрөнгө оруулалт нэмэгдсэн нь чухал бөгөөд нөгөө талаас ОУВС-ийн хөтөлбөр хэрэгжиж, дотоод эдийн засгийн бодлогууд зөв, тууштай явсны үр дүн юм.

Хэдийгээр эдийн засгийн дүр зураг гэгээлэг болсон хэдий ч эрсдэлүүд оршсоор байгааг эдийн засагчид анхааруулж байна. Тэдгээрийн тэргүүн эгнээнд бичигдэхүйц нь манай улсын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны хоцрогдол юм. 2017 онд өргөтгөсөн санхүүжилтийн

хөтөлбөр хэрэгжиж манайд итгэх итгэл сэргэсэн хэдий ч ФАТФ-ын Ази, номхон далайн бүсийн байгууллагаас анхааруулга ирсэн. Уг байгууллага нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх (МУТСТ) ФАТФ-ын зөвлөмжийн хэрэгжилтийг бүс нутгийн орнууддаа хангуулах үйл ажиллагааны чиглэлтэй. Харамсалтай нь Монгол Улс тэдгээр зөвлөмжүүдийг хэрэгжүүлэхгүй байгаа тул "Хар жагсаалт"-д орох эрсдэлтэй байгааг анхааруулсан юм.

Хар жагсаалт гэдэг бол үндсэндээ гадаад орнуудаас холбоогоо таслахтай ижил утгатай. Иймд үүнээс хойш Монгол Улсын МУТСТ чиглэлээр хууль эрх зүйн орчинд шинэчлэлт хийгдэж, тэдгээрийн хэрэгжилтийн хүрээнд ихээхэн

ахиц гаргаснаар "Хар жагсаалт"-д орох эрсдэлээс зайлсхийж, улмаар "Саарал жагсаалт"-д орох эрсдэлийг бууруулж эрчимтэй хяналтад ороод явж байна. Эрчимтэй хяналт гэдэг нь манай улсын хүчин чармайлт, идэвхи зүтгэлийг үнэлэн саарал жагсаалтад орох эсэхийг хэлэлцэх хугацааг сунгаж, боломж олгож байгаа явдал юм.

Тэгвэл өнөөг хүртэл юу хийгдсэн, цаашлаад юу хийх ёстой байгааг дурдах нь зүйтэй байх. Юун түрүүнд МУТСТ тухай хуулийг шинэчлэн найруулж, дагалдах хуулиудад өөрчлөлт оруулснаар ФАТФ-ын зөвлөмжийг биелүүлэх хууль, эрх зүйн орчныг бүрдүүлсэн. Хуулийн үг хэллэгийг зөвлөмжүүдтэй нийцтэй болгож өгснөөр, түүнийг дагаж гарах журам, тэдгээрийн хэрэгжилтийг хангах өргөн хүрээний

ажлууд хийгдэж байна. Тухайлбал, МУТСТ Үндэсний зөвлөл, Хамтын ажиллагааны зөвлөл болон Терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх ажлыг зохицуулах зөвлөлийг тус тус байгуулснаар улс орны бүх салбарт ажиллах боломжийг бүрдүүлэв. МУТСТ гэдэг ойлголт нь угаас улсын хэмжээнд, бараг бүх салбарын хүчин чармайлт, оролцоотой хэрэгжиж байж сая үр дүнтэй болох ёстой. Хэрэв аль нэг салбар алдаа, дутагдалтай байвал улс орон мөнгө угаах, терроризмыг дэмжих, гэмт хэргийн санхүүжилтийг төвлөрүүлэх бай болж тэр чигээр эрсдэлд оруулах аюултай.

МУТСТ үйл ажиллагааны үндсэн чиглэлтэй этгээд нь Монголбанкны дэргэдэх Санхүүгийн мэдээллийн алба юм. Уг байгууллага нь хэдийгээр Монголбанкны дэргэд гэж байгаа боловч бие даасан үйл ажиллагаатай бөгөөд санхүүгийн тогтолцоонд дахь бүх эргэлзээтэй, аюултай гүйлгээнүүдийг шалгаж, хөрөнгийн эх үүсвэрийг тодорхойлон, илрүүлдэг. Энэ ч утгаараа МУТСТ асуудлаар Монгол Улсыг төлөөлж ФАТФ-ын Ази номхон далайн бүсийн уулзалтуудад оролцож хэрэгжилтийг танилцуулдаг байна. 2017 оноос хойш Монгол Улсын МУТСТ тогтолцоонд ахиц гарсан ба үүнд гол үүрэгтэй оролцсон этгээд бол Санхүүгийн мэдээллийн алба гэж хэлэхэд дэгсгүүлсэн болохгүй.

Манай орны МУТСТ үйл ажиллагааны хоцрогдол ихэвчлэн

хэрэгжилт дээр байгааг талууд онцолж байна. Тэр дундаа хууль хүчний байгууллагын зүгээс илүү их хүчин чармайлт гаргах шаардлагатай байгаа аж. Саяхныг хүртэл МУТСТ хуулиар шийдэгдсэн хэрэг бараг байдаггүй байсан. Гэтэл гэмт хэргээс үүсэлтэй хөрөнгө мөнгийг нууж, далдлах зорилгоор хэлбэрийг нь өөрчилж л байвал мөнгө угааж байгаа хэрэг болно. Цаашлаад төрийн ордонд халдаж, терроризмын хэв шинж бүхий гэмт хэрэг үйлдсэн этгээдэд өршөөл үзүүлсэн нь эргээд асуудал болсон байдаг. МУТСТ үйл ажиллагаа бол банк санхүүгийн тогтолцооноос аль эрт хальсан бөгөөд үл хөдлөх хөрөнгө зэрэг өмчлөлийн өөр хэлбэрүүдэд шилжих боломжийг олгох эрсдэлтэй гэж үздэг. Энэ утгаараа сүүлийн үед хуулийнхны зүгээс шүүх, прокуророос авахуулаад нотариатчдын ажил хүртэл эргэлзээтэй этгээдийг илрүүлэх шаардлагыг бий болгож байна. Цагдаа, тагнуулын байгууллагуудын үүрэг, роль ч энд чухал.

Өнөөгийн байдлаар зохицуулалтын түвшинд ч тэр, хэрэгжилтийн түвшинд ч тэр хамгийн том ахиц гаргасан салбар банк, санхүү аж. Гэтэл бусад салбарын хоцрогдол эргээд банкинд хамгийн их хохирол учруулах юм байна. Өөрөөр хэлбэл, би эмх цэгцтэй, ажлаа сайн хийдэг байлаа ч багт маань хамт ажиллаж байгаа нөхөр ажлаа олигтой хийдэггүй, багийн оноог арагш нь татдаг бол манай баг зорьсон хугацаанд зорилтдоо

хүрч чадахгүй. Ер нь саарал жагсаалтад орвол хамгийн түрүүлж банкны гүйлгээ, төлбөр тооцоо нь саатаж манайхтай хамтарч ажиллах хүнгүй болно. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дээр хойрго ханддаг улсыг хар, саарал жагсаалтад оруулдгийг дурдсан бөгөөд уг жагсаалтад орсон улстай хамтарч ажиллах, мөнгөн гуйвуулгыг дамжуулах нь өөрөө тэдгээр этгээдийн мөнгө угаах үйл ажиллагааг дэмждэг мэт ойлголтыг төрүүлэх учраас их болгоомжилдог. Хэрэв ийм муу юм болвол бидэнд итгэх улсын тоо цөөрч, манай зээлжих зэрэглэл ч унана. Нөгөө бууруулах гээд байгаа зээлийн хүү эсрэгээрээ өснө гэсэн үг. Энэ нь иргэд бидний амьдралд шууд нөлөөлөх учраас хэрхэвч хүлээн зөвшөөрч болохгүй.

Ийм учраас мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэдэг бол Монгол Улсын хувьд холын зүйл биш. Харин ч юу юугүй хаалган дээр ирж байгаа атгаалжин хар мангас юм. Хэрэв мангас хаалгыг маань эвдээд орж ирвэл хэний буруу вэ гэдгийг яриад ч нэмэргүй. Одоо боломж олдож байгаа дээр бүх эрсдэлээс сэргийлэх шаардлагатай. Үүн дээр төрийн байгууллагууд, хувийн хэвшлийн идэвх зүтгэл, хамтын ажиллагаа маш чухал. Үүнийг л тал бүрдээ ойлгож энэ оны 10 сард болон дараа дараагийн Ази номхон далайн бүсийн уулзалтад бэлтгэх нь зүйтэй билээ.

ТӨВ БАНКНЫ ХАРААТ БУС БАЙДЛЫГ ХЭРХЭН БАТАЛГААЖУУЛАХ ВЭ?

ЭДИЙН ЗАСАГЧ Ж.ДЭЛГЭРСАЙХАН



Төв банкны үүрэг бол ханшийн тогтвортой байдал гэхээсээ илүү үнийн тогтвортой байдал байх нь зүйтэй. Монголбанкны үүргийг бид хаана хаанаа ухамсарлах ёстой. Монголбанк валютын ханшийг барьж чадахгүй. Үндсэндээ валютын ханшийн урт хугацааны тогтвортой байдлыг хангах, ажилгүйдлийг бууруулах зэрэг макро эдийн засгийн зорилгыг хэрэгжүүлэхэд Засгийн газар л илүү их үүрэгтэй. Ялангуяа улс төрийн нөхцөл байдал тогтворгүй байгаа үед Валютын зохицуулалтын хуульд үүнийг зааж өгөхгүй бол Засгийн газар өөрийнхөө хийх ёстой ажлыг хийгээгүйнхээ төлөө төв банк руу дайрах хандлага байгаад байна. Их хурлын дурын нэг гишүүн валютын ханшаа буулгаач гэж Монголбанк руу дайрдаг тогтолцоо манайд хэвийн зүйл болчихсон. Нийт иргэдийн дунд ч бас валютын ханш Монголбанкны асуудал юм байна гэдэг ойлголт үүсчихээд байгаа. Гэтэл валютын ханш дээр бага зэргийн давхцал ЗГ болон Монголбанк хооронд байдаг боловч валютын урсгал, экспортыг нэмэгдүүлэх, ажилгүйдлийг бууруулах замаар иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, валютын ханшийн суурь нөхцөлийг бүрдүүлэх нь Засгийн газрын хийх ёстой ажил гэдэг нь бүх онол, олон улсын судалгаагаар батлагдсан зүйл. Монголбанк ганц л зүйлийг хийж байгаа. Валютын нөөцийг удирдаж, огцом савлагаа үүссэн үед боломжийнхоо хэрээр оролцож байгаа. Хэдийгээр хуулиндаа ханшийн тогтвортой байдал гэж байгаа ч академик хүрээнд үүнийг зөвөөр ойлгож, зөвөөр тайлбарлаж, улстөрчдөд хүргэвэл тэд дураараа орилохгүй болов уу. Үүнээс гадна төв банкны хараат бус байдлыг бид ийм түвшинд ингэж ярьж байгаа нь өнөөдрийн бидний улс төрийн орчны доройтол, улстөржилт, амлалт, популизмын үр нөлөө гэж харж байгаа. Бид өнөөдөр Үндсэн хуулиндаа хүртэл суулгах хэмжээнд яриад байж байна. Хэрвээ төрөө дээдэлдэг, хуулиа дээдэлдэг, зөв улс төрийн орчинтой байсан бол Монголбанкны бие даасан байдал хангагдах түвшин хууль эрх зүйн хувьд 70-80 хувьтай байгаа. Гэтэл Ж.Түвшинжаргал судлаачийн судалгаагаар 40-50 хувьтай гарч байгаа нь хуулийг хэрэгжүүлдэггүй, үл огоордог байдлаас болоод байгаа юм.

ЭДИЙН ЗАСАГЧ С.ДЭМБЭРЭЛ



Английн парламент дээр төв банкны Ерөнхийлөгч нь орж ирээд 2 цаг гаруй илтгэлээ тавиад, гишүүдийнхээ асуултанд хариулчихаад гараад явдаг юм билээ. Энэ нь илтгэл шүү, тайлан биш. Энэ бол төв банкны онол болон практикт хэрэгждэг бие даасан байдлын сонгодог, энгийн жишээ. Монголд ийм юм байхгүй л дээ. Магадгүй 100 жилийн дараа бий болж магадгүй, яагаад гэвэл бидний сэтгэлгээ тийшээ очоогүй байна. Миний бодлоор цаашид хуулийг сайжруулах тал дээр нэг зүйл оруулах хэрэгтэй. Зорилгын бие даасан байдал гээд сая ярьсан. Энэ маргаантай л байдаг. Гэхдээ миний хатуу итгэл бол “Үнийн тогтвортой байдал” байх ёстой. Өнгөрсөн жил Их хурал дээр энэ эзаалт унасан. Яагаад гэвэл ойлголтын зөрүү байсан. Юу гэхээр үндэсний мөнгөн тэмдэгт — төгрөгийн тогтвортой байдал гэдэг нь нэгдүгээрт инфляци, хоёрдугаарт ханш. Инфляци нь дотоод тогтвортой байдал, ханш нь гадаад тогтвортой байдал. Манайх шиг улсууд ханшийг тогтвортой байлгая гэвэл хоёр л арга бий. Нэгдүгээрт, Америкийн Холбооны нөөцийн банк руу захидал бичих. “Манайх Чингисийн Монгол учраас манай ханшийг тусдаа байлгаж өгөөч ээ” гэж гуйх. Мэдээж энэ бол боломжгүй. Хоёрдугаарт, ханшийн дэглэмийг солих. Одоогоор манай ханшийн дэглэм бол зохицуулалттай, хөвөгч ханшийн дэглэм гэж явж байгаа. Зохицуулалттай гэдэг дотроо хэт их зохицуулалттай байна уу, бага зохицуулалттай байна уу гэдгийг хууль эрх зүйн талаас нь анхаарах ёстой. Монголбанкны бие даасан, хараат бус байдалд нь шууд хуулиар халдаж байгаа тохиолдол байна. Тухайлбал, зээлийн хүүгийн дээд хязгаарыг тогтоох, мөнгө хүүлэлтэй тэмцэх тухай хууль байна. Хоёр заалттай хуульд юу гэж заасан гэхээр зээлийн хүү нь төв банкны үнэт цаасны хүү дээр нэмэх нь тэд байна гээд л тусгаад өгчихсөн байгаа юм. Бид маш олон жилийн турш мөнгөний бодлогын бие даасан байдал, мөнгөний бодлогын шилжих механизм, сувгуудыг сайжруулах талаар олон янзын судалгаа хийсэн. Тэр бүх зүйл хэрэггүй болох нь. Хэрвээ ингээд заагаад өгчихвөл мөнгөний бодлогын шилжих сувгийн талаар яриад ч хэрэггүй болох биз.



МОНГОЛБАНКНЫ ХАРААТ БУС БАЙДАЛ

Төв банкны нээлттэй байдлыг сайжруулж, хараат бус байдлыг бэхжүүлэх нь эдийн засаг болон санхүүгийн тогтвортой байдлыг хангахад чухал.

Төв банкны хараат бус байдал хангагдахгүй байснаар үүсч болох эрсдэл



Төв банкны зорилт нь тодорхойгүй, давхар утга илэрхийлдэг байх нь бодлогын хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж, олон нийтийн итгэх итгэлийг сулруулна.

Урт хугацаанд хэрэгжиж, үр дүнгээ өгөх бодлогод богино хугацаанд өөрчлөлт оруулснаар улс төрийн нөлөөллийг нэмэгдүүлнэ.



Мөнгөний бодлогын хорооны гишүүдийг богино хугацаанд өөрчлөх нь мэргэжлийн түвшинд тууштай ажиллахад хүндрэл үүсгэнэ.

Төв банкны хараат бус байдал хангагдсанаар үүсэх давуу талууд

Бодлогын тууштай байдлыг хангаж, мөнгөний бодлогын арга, хэрэгслийг бие даан сонгож хэрэгжүүлснээр олон нийтийн итгэх итгэл, үр нөлөөг нэмэгдүүлнэ.


УИХ-аас үүрэг даалгавар, чиглэл өгөх боломжтой одоогийн эрх зүйн орчинг сайжруулснаар Төв банк үндсэн зорилтоосоо хазайсан үйл ажиллагаа эрхлэх эрсдэлийг хязгаарлах ач холбогдолтой.

Төв банкны үндсэн зорилттой шууд холбоогүй шалтгаанаар удирдлагыг солих, цаашлаад санхүүгийн хараат бус байдлыг бэхжүүлснээр үйл ажиллагааны зарчмыг хадгалах давуу талтай.

Хараат бус байдал, ил тод байдал нь нэг зоосны хая тал бөгөөд хуулиар Төв банкны хараат бус байдлыг нэмэгдүүлснээр хариуцлагын зарчим сайжирч, улмаар ил тод байдал нэмэгдэнэ.

МОНГОЛБАНКНААС ХЭРЭГЖҮҮЛЖ

Монголбанк нь ил тод байдлаа нэмэгдүүлэхэд зорьж, үүний тулд олон нийтэд төв банкны үйл ажиллагааг таниулахад чиглэсэн зорилтод үйл ажиллагаанууд явуулж байна. Тэдгээрийн нэг нь 2017 оноос арилжааны банкуудтай хамтран харилцагч, иргэдэд зориулсан аянууыг хэрэгжүүлдэг боллоо. Сүүлийн байдлаар “Эх орныхоо алтыг Эрдэнэсийн сандаа”, “Хариуцлагатай харилцагч-Хариуцлагатай банк” аян орон даяар хэрэгжиж байна. Эдгээр аяны хэрэгжилттэй холбоотой мэдээллийг хүргэж байна.



Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газрын Эрдэнэсийн сангийн ахлах эдийн засагч **Д.АЛТАНСҮХ**

Алтын худалдан авалт сүүлийн жилүүдэд сайжрахад нөлөөлсөн нэг чухал хүчин зүйл бол Монголбанкнаас үнэт металлын худалдан авалтыг нэмэгдүүлэх зорилготой бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлж байгаатай холбоотой юм. Үүний тулд үнэт металл худалдан авах үнийн бодлогоо шинэчилж, дэлхийн зах зээлийн үнэтэй нийцүүлсэн, алт худалдан авах цагийн хуваарьтаа өөрчлөлт оруулж, тухайн өдрийн арилжаанаас хоцорсон ч тэр өдрийн алтны үнээр хадгалуулж, дараагийн өдөр төлбөр тооцоог шилжүүлдэг гэх зэрэг юм. Эдгээр бодлогын шинэчлэлээс гадна “Алт 2” Үндэсний хөтөлбөрийн хүрээнд 2017 онд гурван сарын хугацаатай “Монгол алт” аяныг анх өрнүүлж, улмаар 2018 онд дахин таван сарын хугацаанд “Эх орныхоо алтыг Эрдэнэсийн сандаа” аяныг хэрэгжүүлж, 2019 оны дөрөвдүгээр сарын 1-ний өдрөөс зургаан сарын хугацаанд “Эх орныхоо алтыг Эрдэнэсийн сандаа” аяныг үргэлжлүүлж байна. Ийнхүү тасралтгүй аян зохион байгуулж байгаа зорилго бол аж ахуйн нэгж, байгууллагууд олборлосон алтаа Монголбанк болон арилжааны банкуудад худалдаж, алт худалдан авалтыг нэмэгдүүлэх, олон нийтийн дунд алт худалдан авах үйл ажиллагааны талаар сургалт, сурталчилгааг эрчимжүүлэх, холбогдох хууль, журмыг таниулахад

юм. Мөн Монгол Улсын гаалиар зөвшөөрөлгүй алт гаргах үйлдлийг бууруулах, хариуцлагатай уул уурхайг дэмжих, тэдний үйл ажиллагааг иргэдэд сурталчлах, Монголбанкны худалдан авч буй алтны үнийн талаар болон бусад мэдээллийг олон нийт, байгууллагад хүргэх, таниулахын төлөө ажиллаж байна. Энэ хүрээнд бид 2017 оноос эхлэн алт тушаагч байгууллага, иргэдийн үйл ажиллагааг дэмжих, идэвхжүүлэх зорилгоор “Гэрчлэх бичиг” олгодог болсон. Мөн 2018 оны аравдугаар сард Дархан-Уул, Баянхонгор аймагт сорьцын лаборатори байгуулан, алт худалдан авалтын нэг цэгийн үйлчилгээг байгуулаад байна.

Энэ бүхний үр дүнд Монголбанкны алт худалдан авалт 2017 онд түүхэндээ анх удаа 20 тн хүрсэн бол 2018 онд 22 тн болж, 2010 оны худалдан авалттай харьцуулахад 10 дахин, 2014 оны худалдан авалтаас 72%-иар тус тус өссөн. Үнэт металл худалдан авах ханшийн хувьд 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрөөс Монголбанкинд худалдан авах алтны үнийг Лондонгийн үнэт металлын зах дээрх хамгийн сүүлийн алтны үнээс 2 ам.долларыг, цагаан мөнгөний үнийг Лондонгийн үнэт металлын зах дээрх хамгийн сүүлийн цагаан мөнгөний үнээс 1 ам.долларыг хасч тооцдог болоод байна.

БУЙ АЯНУУДЫН ҮР ДҮН



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК



ХАДГАЛАМЖИЙН
ДААТГАЛЫН
КОРПОРАЦИ
HADAALAMJIJIN DAATGALYN KORPORATSII



MVA
МОНГОЛЫН БАНКНЫ ХӨЛӨС



Finanzgruppe
Sparkassenstiftung für
internationale Kooperation

"ХАРИУЦЛАГАТАЙ ХАРИЛЦАГЧ - ХАРИУЦЛАГАТАЙ БАНК"

АЯН



Хяналт шалгалтын газрын
хянан шалгагч **Б.ХАЛИУНАА**

Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 5 дугаар зүйлд Монголбанкны үндсэн үйл ажиллагааны чиглэлүүдийг тодорхойлсон байдаг. Монголбанк нь банкны харилцагч, хадгаламж эзэмшигчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор банкны үйл ажиллагаанд хяналт тавьдаг. Монголбанк Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа дотоодын арилжааны банкуудад Банкны тухай хууль, бусад хууль, тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтийг хангуулж ажилладаг гэсэн үг. Төв банк банкуудын үйл ажиллагаанд хяналт тавих зорилгоор зайнаас хяналт тавих, газар дээрх иж бүрэн болон хэсэгчилсэн шалгалт хийх гэх зэрэг хяналт шалгалтын төрөл бүрийн хэрэгсэл ашигладаг.

Монголбанк нь харилцагчийн эрх ашгийг хамгаалах, банкны салбарын тогтвортой байдалд дэмжлэг үзүүлэх зорилгоор "Хариуцлагатай харилцагч- хариуцлагатай

банк" аяныг хэрэгжүүлж байна. Тус аяны хүрээнд хэрэглэгчийг санхүүгийн үйлчилгээ, хадгаламжийн даатгалын тогтолцооны талаар хангалттай ойлголттой болоход дэмжлэг үзүүлж хохирохоос хамгаалах, нөгөө талаас хариуцлагатай харилцагчийг төлөвшихөд дэмжлэг үзүүлэх юм. Түүнчлэн, банкуудын үйл ажиллагааг илүү ил тод болгох арга хэмжээг авах юм.

Тус аяны хүрээнд банкны санхүүгийн чадавхийг илэрхийлдэг үзүүлэлтүүдийг иргэдэд ойлгомжтой мэдээлж, тайлбарлах, санхүүгийн бүтээгдэхүүнүүдийг зохистой сонгоход дэмжлэг үзүүлэх, хадгаламжийн даатгалын тогтолцооны талаар бүрэн мэдээлэл өгөх, банкны үйл ажиллагааны талаарх цогц ойлголтыг олгох сургалтуудыг зохион байгуулах, хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон Монголбанк, арилжааны банкуудын салбар нэгжүүдээр мэдээлэл хүргэж ажиллана.


МОНГОЛБАНКНЫ ЭРДЭНЭСИЙН САНГААС

ТӨРЦ АЛТ

Бохир жин: 1035.7 гр
Цэвэр жин: 935.76 гр
Сорьц: 903.6

Үрээ тэвэрсэн эхийн хэлбэртэй
байгалийн төрц алт.





ЛОРД КЕЙНС ОУВС-Д ЗОЧИЛСОН НЬ

Энэ жил ОУВС байгуулагдсаны 75 жилийн ой тохиож байгаа билээ. Тэртээ 1944 оны зун Бреттон Вудсын системийг бий болгосон бөгөөд үүний дагуу Дэлхийн Банк, ОУВС байгуулагдсан байдаг. Их Британийн Лорд Жон Мейнард Кейнс нь тус системийг бий болгоход томоохон үүрэгтэй оролцсон нэгэн бөгөөд ОУВС-г үүсгэн байгуулах, үйл ажиллагааны чиглэлийг нь тодорхойлоход томоохон дуу хоолой болж байв. Тэгвэл 75 жилийн дараа, хэрэв өнөөдөр Кейнс ОУВС-ийн Төв оффисоор зочилбол ямар яриа болох байсан бол?

Хамгаалагч дэгжин хослол өмсөж, судалтай зангиа зүүсэн, ахимаг насны эрхэмд хандан: "Бичиг баримтаа, би таны бичиг баримтыг шалгах ёстой" хэмээн хэлэв. Үргэлжлүүлэн "Та хэн бэ? Таны нэр хэн бэ?" гэв.

КЕЙНС: Жон Мейнард Кейнс. Лорд Кейнс

-Ийм байна найз аа. Бөгжний эзэн ч бай (лорд гэдэг үгийг егөөджээ), үгүй ч бай биеийн байцаалтыг тань үзэж байж би сая таныг барилга руу нэвтрүүлж болно

Энэ мөчид нэг албан хаагч ажлаасаа хоцорч байгаа бололтой яарч өнгөрөв. Тэрхэн мөчид тэрбээр зогтусан эргэн харлаа. Энэ чинь Кейнс байна шүү дээ! Кейнсийн хүрэл баримал захирлуудын зөвлөлийн өрөөнд байршдаг учир түүний царайг төвөггүйхэн таних нь тэр. Тэрбээр "Намайг өршөөгөөрэй" гэж хэлэхтэй хамт хамгаалагчид ажлын картаа үзүүлээд "Би энэ эрхмийг хариуцаад явъя" гэлээ.

Хамгаалагч зөвшөөрч, "Түүнд зочдын карт өгөх ёстой шүү" гэж анхааруулав.

Тэд ОУВС-ийн Төв байранд нэвтрэх нь тэр. "Уучлаарай, Лорд Кейнс, та энд сууж байхгүй юу. Би..."

"Та нар намайг ирнэ гэж мэдээгүй хэрэг үү? Миний явуулсан телеграм энд ирээгүй гэж үү?" хэмээн Кейнс асуув.

"Юу...? Үгүй гэж хэлэх үү дээ. Би түргэхэн Удирдах

захирлын ажлын албатай холбогдъя. Тэд энэ асуудлыг шийднэ гэдэгт итгэлтэй байна."

"Би бага зэрэг хоцорчихлоо. Америкт галт тэрэг хэзээ ч цагтаа байдаггүй шүү дээ..." гэж Кейнс амандаа бувтнан арьсан сандал дээр суув. Барилгын 1 давхарт янз бүрийн далбаа байдаг учраас түүний нүд эрээлжилсэн бололтой.

Бараг 20 минут өнгөрсний дараа л нэг юм албан хаагч эргэж ирээд, "Удирдах захирал таныг хүлээж авахдаа таатай байна" гэж мэдэгдэв.

КЕЙНС: Түүний урилгад баярлалаа. Гэхдээ, юу... тэр ноёнтны нэр хэн бэ?

-Лагард. Кристин Лагард

КЕЙНС: Хатагтай хэрэг үү? Франц хатагтай?

Албан хаагч толгой дохилоо.

КЕЙНС: За тийм байж. Тэгвэл No.2 албан тушаалтан байгаа байх аа?

-Тэргүүн дэд удирдах захирлыг Дэвид Липтон гэдэг бөгөөд Америк хүн байгаа.

КЕЙНС: Тийм, Америкчууд байлгүй яахав. Гэхдээ мэдээж No.3 байгаа, тийм үү? Британи улс квотын хэмжээгээрээ 2-т бичигддэг биз дээ.¹ Би өөрөө хэлэлцэж, тохиролцож байсан учир сайн санаж байна.

Албан хаагч эвгүйхэн ханиалгаж, хоолойгоо засаад “Үнэнийг хэлэхэд Япон улс одоо ОУВС-ийн гишүүн орнуудаас квотын хэмжээгээрээ 2-т ордог болсон. Дараа нь Хятад болон Герман улс байгаа” гээд, “Их Британи 5 дугаарт Франц улстай зэрэгцэж байгаа” гэж тайвшруулахыг оролдов.

Кейнс удирдах захирлын өрөө рүү явах замдаа энэ бүх шинэ мэдээллийг тунгаалаа.

КРИСТИН ЛАГАРД: Лорд Кейнс, тантай уулзах нэр төрийн хэрэг.

КЕЙНС: Enchantй, маш таатай байна Хатагтай.

КРИСТИН ЛАГАРД: Таныг хүндэтгэн хүлээж авч чадаагүйд уучлаарай. Үнэнийг хэлэхэд бид ийм зүйл болно гэж мэдсэнгүй...

Кейнс инээвхийлээд “Би ойлгож байна. Би хэсэгхэн ‘урт хугацаанд’ байж байгаад ирлээ”. Гэхдээ ОУВС-ийн 75 жилийн ойн өдөр зочлохгүй байж чадсангүй.”

Лагард түүнийг буйданд суулгаж, Неспрессо машинаараа 2 аяга кофе бэлтгэж эхлэв.

Тэгэхээр, “Та надад хэлнэ үү” гээд “ОУВС амжилттай байж чадав уу. Одоо юу болж байна? Миний ойлгосноор ‘Конференц’ болсны дараа зарим өөрчлөлт гарсан байна” хэмээн Кейнс үргэлжлүүлэв.

ЛАГАРД: Хаанаас эхлэхээ би төдийлөн мэдэхгүй байна. Маш их өөрчлөлт гарсан гэж Лагард хариуллаа.

КЕЙНС: За, Дүрмийн хувьд. Бидний үг бүрчлэн хэлэлцсэн зүйлс өөрчлөгдөөгүй байх гэж найдаж байна.

ЛАГАРД: Ерөнхийдөө үгүй. Гэхдээ зарим нэг нэмэлт өөрчлөлт орсон.

КЕЙНС: Тухайлбал юу гэж?

ЛАГАРД: Анхны нэмэлт өөрчлөлт нь ЗТЭ-ийг бий болгоход чиглэж байсан. Задалж хэлбэл Зээлжих тусгай эрх. Энэ нь юу л даа... тайлбарлахад төвөгтэй юм. Гэхдээ үүнийг Төв банкуудын хоорондох виртуал валют гэж ойлгож болно. Энэ нь шаардлагатай үед олон улсын мөнгөний тогтолцоонд хөрвөх чадварыг бүрдүүлэхэд чиглэдэг. 2009 онд бид үүнийг ашиглаж асар том хуваарилалт хийсэн.

КЕЙНС: Миний ярьж байсан банкортой ижил сонсогдож байна.

ЛАГАРД: Тийм ээ, яг тийм. / Лагард инээв./ Би мартжээ. Танд ЗТЭ хэрхэн ажилладгийг тайлбарлах нь илүүц байж. За өөр юу билээ, аан тийм. Өөр нэг томоохон өөрчлөлт бол дүрэмд хоёрдох удаагаа нэмэлт өөрчлөлт оруулсан явдал байсан. Үүнийг хөвөгч ханшийн дэглэм хэмээн тодорхойлсон.

КЕЙНС: Хөвөгч ханш аа? Гэхдээ бид дайны дараа эмх замбараагүй зүйл болж байх үед ханшийн тогтвортой байдлыг бий болгохын тулд ОУВС-г байгуулсан шүү дээ.

ЛАГАРД: Бреттон Вудсын тогтвортой ханшийн тогтолцоо 1970-аад онд нуран унасан.

КЕЙНС: Тэгвэл ОУВС яагаад одоо хүртэл ажиллаж байдаг билээ?

ЛАГАРД: Тогтвортой ханшийн тогтолцоо үгүй болсон ч дэлхий нийтэд бид хэрэгтэй гэдгийг удалгүй ойлгосон. Нөгөөтэйгүүр, хөвөгч ханшийн дэглэм бий болсон ч, бид улс орнууд ханшид нөлөөлөх замаар худалдаанд шударга бус давуу тал бий болгохтой тэмцэж, гишүүн орнуудын ханшийн бодлогод хатуу хяналт тавьж эхэлсэн.

КЕЙНС: Тэгэлгүй яах вэ. Тэгээд тэд та нарын үгийг сонсож байх юм уу?

Лагард инээвхийлж, “Юу л даа, үргэлж биш” гэлээ. “Худалдаанд ашигтай байгаа улсуудыг ханшаа ам.долларын эсрэг чангаруулахгүй байна” гэж АНУ гомдоллох болсон. Тэдгээр улс өмнө нь Герман, Япон улс байсан бол саяхнаас Хятад улс болж хувирлаа. Бүр хэдхэн жилийн өмнө бидний үндсэн үүрэг хяналт тавих ажиллагааг АНУ шүүмжилж “унтаагаараа жолоо барьж буй” мэт гэж зүйрлэсэн.

КЕЙНС: Би тухайн үед Харри Декстер Уайтад үүнийг хэлж байсан юм. Чи ОУВС-ийн эрх мэдлийг ашиглах замаар худалдааны ашигтай байгаа улсуудыг тохируулга хийхийг шаардаж, санг нэг ёсондоо хазгануулж болохгүй гэж анхааруулсан. Миний хувьд ашигтай болон алдагдалтай байгаа улсууд ижил тэнцүү төлөөс төлөх ёстой гэж хүсэж байлаа. Гэхдээ Уайт болон АНУ-ын Сангийн яамны зүгээс ихээхэн эсэргүүцэлтэй тулгарсан л даа. АНУ үргэлж худалдаанд ашигтай байж чадахгүй ээ. Алдагдалтай ажиллаж эхлэх үед чи харамсах болно доо гэж би түүнд анхааруулж байв.

Хариуд нь тэр 'наадах чинь хамаагүй ээ, АНУ үргэлж чөлөөт худалдааны төлөө тэмцэгч байх болно' гэсэн. Одоо хэвээрээ биз дээ?

Бараг л... гэж Лагард "хуурай" хариулав.

КЕЙНС: Тэгэхлээр Төв банкууд валютын захад оролцохоо больсон хэрэг үү?

ЛАГАРД: Хөвөгч ханшийн дэглэмтэй бол үгүй гэсэн үг. Тэд зах зээлд эмх замбараагүй байдал бий болсон тохиолдолд л интервенц хийх замаар оролцох юм.

КЕЙНС: Зах зээл чинь өөрөө эмх замбараагүй биш билүү?"

Лагард кофегоо авахаар кофены машин руу боссоноо бодлоо өөрчилж, өөр зүг рүү явав. Оронд нь модон хийцийн хананы ард талын хөргөгчнөөс Ла Гранде Дам оргилуун дарс гаргаж ирлээ.

"Яасан аятайхан юм бэ" гэж Кейнс инээвхийлэн уулга алдаад, "Та сонсож л байсан байх, миний амьдралдаа харамсаж явдаг нэг зүйл бол энэ..."³ Тэр босоод Лагард руу дөхөж очлоо.

-Би ажлаа хүлээж аваад үүнийг энэ хөргөгчнөөс олсон юм. Би тун онцгой өдөр задлахаар хүлээж байлаа. Тэр бол гарцаагүй өнөөдөр хэмээн Лагард инээмсэглэнгээ түүнд хундагалан барив.

Тэд хундага тулгасны дараа Кейнс суудал руугаа буцаж суунгаа, "Та надад хэлээч, банкерын санаа хэрхэн хэрэгжсэн бэ? Түүнийг юу гэж хэллээ? Зээлжих тусгай эрх гэсэн байх аа? Тэгээд та нар хэдэн жилийн өмнө томоохон хуваарилалт хийсэн гэж байсан. Яагаад тэгсэн гэлээ?" Кейнс асуув.

Лагард түүн лүү ширтэж байснаа, "Мэдээж та олон улсын санхүүгийн хямралын талаар сонсоогүй байх."

КЕЙНС: Мэдээж үгүй! Бидэнд дахиад Их хямрал тохиолдсон хэрэг үү?

ЛАГАРД: Үгүй ээ. 10 жилийн өмнө дэлхий нийтийг хамарсан томоохон санхүүгийн хямрал тохиолдсон бөгөөд Их хямрал руу хөтөлж байсан. Аз болоход бидэнд таны онол байлаа. ОУВС-аас яаралтай арга хэмжээ авч, улс орнуудыг төсвөө их хэмжээгээр тэлэх болон мөнгөний бодлогоо хүчтэй зөөлрүүлэхийг уриалсан.

КЕЙНС: Тэгээд уналт зогссон уу?

ЛАГАРД: Зарим талаар зогссон. Тэр цагаас хойш дэлхийн эдийн засаг байнга бага зэргийн "доргиотой" байх болсон.

КЕЙНС: Эдийн засгийг сэргээх төсвийн арга хэмжээ үр дүнгээ өгсөн үү?

ЛАГАРД: Тийм ээ, маш сайн нөлөөлсөн. Гэхдээ асуудал нь зарим улсын засгийн газар зардлаа хэт нэмэгдүүлснээр өрийн хэмжээгээ маш их өсгөсөн.

КЕЙНС: Тэгвэл хэт зөөлөн мөнгөний бодлогын хувьд...?

ЛАГАРД: Гарцаагүй чухал байсан.

КЕЙНС: Гэхдээ энэ нь мөнгөний урсгалыг хурдасгаж, халалтыг үүсгээгүй юу. Эсвэл өнөө цагт хөрөнгийн урсгалын удирдлага тийм сайн болсон хэрэг үү?

Лагард мөрөө хавчисхийн, "Тэр цагаас хойш хөгжиж байгаа эдийн засгууд руу маш их мөнгө урссан. Нөгөө талаас тэдгээр улсын компаниудын валютын эрсдэлийн хэмжээ аюултай хэмжээнд хүртлээ өссөн."

"Ашиг өгөх актив нь дээд зэргээр ашиглаж болох чиглэл рүү урсаж байх нь зөв. Гэхдээ ямар ч удирдлагагүйгээр их хэмжээний мөнгөний урсгал бол..." гээд Кейнс толгойгоо сэгсрэв. Тэр үргэлжлүүлэн,

КЕЙНС: ОУВС-ийн дүрмийг боловсруулж байхдаа Уайт бид хоёр энэ тал дээр бүрэн зөвшилцөлд хүрч чадсан. Гэтэл Нью Йоркийн банкирууд бидний боловсруулсан төслийг гацааснаар энэ заалт цааш яваагүй. За тэр ч яахав. Энэ бол олон жилийн өмнөх явдал. ОУВС одоо юун дээр ажиллаж байгаа вэ?

"Маш олон асуудал дээр" гэж Лагард хариуллаа. Дурдсанчлан, хямралаас хойш 10 жил өнгөрсөн ч гэлээ дэлхийн эдийн засаг доргиотой хэвээрээ л байна. Дээр нь орлогын тэгш бус байдал, хүйсийн тэгш байдлыг нэмэгдүүлэх, дэлхийн уур амьсгалын өөрчлөлт гэх мэт бидэнд шинээр өөр асуудлууд тулгарч эхэлсэн.

КЕЙНС: Уур амьсгалын өөрчлөлт гэв үү. Цаг уур гэж та хэлэх гээгүй биз. Уур амьсгал яаж өөрчлөгддөг билээ?

ЛАГАРД: Дэлхий дээр жил бүр хэдэн мянган тонноор хэмжигдэх нүүрс хүчлийн хий болон орчныг бохирдуулагч олон бодис бий болж байна. Энэ нь дэлхийн дундаж температурыг өсгөж, улмаар туйлын мөсийг хайлуулан далайн түвшнийг нэмэгдүүлж байна...

“Тэнгэр минь” гэж Кейнс уулга алдан, наадах чинь аймшигтай сонсогдож байна. Гэхдээ энэ нь ОУВС-д ямар хамаатай юм бэ?

Харин Лагард тайлбарлав. Яг тайлбарлаж дуусч байх үед хаалгыг жигд тогших чимээ сонсогдоно. Туслах нь хаалгаар толгойгоо цухуйлган “Хатагтай Лагард, захирлуудын зөвлөлийн хурал хэдхэн минутын дараа эхлэх гэж байна” гэж мэдэгдлээ.

Кейнс босч зогслоо. Түүний живэр сахал хөдөлж, инээмсэглэл болон хувирав. “Би ОУВС-г зөвлөлтэй байх ёстой гэж үргэлж хэлдэг байсан.”

Лагард гарахаар бэлдэнгээ түүнд хандан, “Та үлдсэн өдрийг сантай танилцаж өнгөрөөхөд зориулж болно шүү дээ.” гэв. Миний туслах таныг дагуулж танилцуулна. Та өөрийн нүдээр сан хэрхэн ажиллаж байгааг үзэж болно шүү дээ. Тэгээд явахаасаа өмнө над дээр эргэж ирэхгүй юу?

* * *

Нар жаргах дөхөж, Вашингтон хотод үзэсгэлэнт зуны үдэш айлчлахад Кейнс Удирдах Захирлын өрөөнд эргэж ирэв.

За, та юу гэж бодож байна? гэж Лагард лавлана.

КЕЙНС: Бүх зүйл өөрчлөгдсөн мэт надад санагдлаа. Миний үед 3 тогтмол байдаг байсан. Цаг уур, үндэсний орлогод ажиллах хүчний эзлэх хувь⁴, эцэст нь – ингэж хэлж байгаад уучлаарай, эмэгтэйчүүдийн нийгэмд эзлэх байр суурь⁵. Одоо энэ бүхэн өөрчлөгдөж. Гэхдээ, нөгөө талаар юу ч өөрчлөгдөөгүй байна. Сангаас улс орнуудын төлбөрийн тэнцлийн асуудлыг шийдвэрлэх тал дээр тусалж, үндэсний болон олон улсын цаашдын төлөвт нөлөөлөх зүйлсийн эсрэг зогсох нь чухал. Сан нь мөн худалдаанаас ашигтай байгаа болон алдагдалтай байгаа улсуудын хувааж болох хүндрэлийг жигд хуваарилахад тусалж, өөрчлөлт ихтэй хөрөнгийн урсгалыг эх үүсвэр болон хүлээж авч байгаа орнуудын хооронд удирдахад дэмжлэг үзүүлэх ёстой. Мөн дэлхий нийтийн хөрвөх чадварыг заримдаа зохицуулж байх шаардлагатай байна. Өөрчлөгдсөн ганц зүйл гэвэл шок үүсэх шалтгаан болон улс орнуудад тулгарч байгаа хүндрэлүүд л аж. Гэхдээ ОУВС-гийн үндсэн үүрэг буюу гишүүн улс орнуудыг эдгээр асуудал, хүндрэлүүдийг даван туулахад туслах шаардлага оршсон хэвээр байна. Бидний Бреттон Вудсын бий болгосон гавьяа нь тогтсон ханшийн тогтолцоотой болох явдал байгаагүй ээ. Гол нь

гишүүн орнууддаа тохируулж, дасан зохицдог, үйлчилж чадах тийм институцийг болгох байсан юм.

-Тэгэлгүй яах вэ гэж Лагард хариулав. Би таныг гаргаж өгье.

Тэд цахилгаан шатанд өөрсдийнхөө бодолдоо автан чимээгүйхэн явлаа.

Хаалга руу гаргаж байхдаа Лагард Кейнсээс, “Танд өөр ажиглагдсан зүйл байв уу?” хэмээн асуув.

КЕЙНС: Тийм. Би орон болгоноос ирсэн, хар цагаан арьстай, эрэгтэй, эмэгтэй хүмүүс нь шашин харгалзахгүй янз янзын ажил хийж нэг дор, нийтийн ашгийн төлөө ажиллаж байгааг анзаарлаа. Би ОУВС-г зөв чиглэлд, зөв удирдлагын доор байгааг ойлголоо.⁶ гэж инээмсэглэн, ОУВС алзахгүй юм байна. Дэлхий алзахгүй юм байна гэлээ.

Кейнс мэхийн ёслоод, баруун хойд 19 дүгээр гудамжны зүг алхан одлоо.

Автор: Атиш Р.Гош /ОУВС-гийн түүхч/

Тэмдэглэгэнүүд:

¹Кейнсийн гайхах нь аргагүй юм. ОУВС-гийн квот шинэчлэх 9 дүгээр үнэлгээ 1990 онд болсон ба тэр хүртэл Их Британи улс квотын хэмжээгээр АНУ-ын дараа 2 дугаарт бичигдэж байсан. 1947 оны байдлаар квотын хэмжээгээр тэргүүлж байсан 5 орныг жагсаавал АНУ 31.68%, Их Британи 15.12%, БНХАУ 6.56%, Франц 6.28%, Энэтхэг 4.85%-ийн квоттой байсан юм.

² Кэйнс “Урт хугацаанд бид бүгд үхнэ” гэсэн алдартай ишлэлээ 1924 онд хэлж байсан.

³ Кейнс нэгэнтээ, “Миний хамгийн их харамсаж явдаг зүйл бол илүү их оргилуун дарс ууж чадаагүй явдал” гэж хэлж байжээ.

⁴ Кейнс 1939 онд үндэсний орлогод эзлэх ажиллах хүчний хэмжээ бол эдийн засгийн бүх статистикаар баталгаажсан гайхмаар факт юм гэж хэлж байсан бол 1980-аад оноос хойш ажиллах хүчний эзлэх хэмжээ дийлэнх хөгжингүй эдийн засгуудад буурч эхэлжээ.

⁵ Кейнс бол эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалахыг хүчтэй дэмжигч хүн байсан. Тэрбээр 1932 онд Мэри Стопсын Нийгэмлэгийн Дэд ерөнхийлөгчөөр ажиллаж байв.

⁶ Гишүүн орнуудын засгийн газраас энэ төрлийн хууль эрх зүйн акт батлахаас өмнө ОУВС-гийн Захирлуудын зөвлөл N1 дүрмийг 1946 оны 9-р сарын 25-ны өдөр баталсан. Уг дүрэмд, ажилтны хүйс, арьс өнгө, шашин шүтлэгийг үл харгалзан ажилд авах, ангилал тогтоох, тушаал дэвшүүлэх, үүрэг даалгавар өгөх шийдвэрийг гаргаж, хэрэгжүүлнэ гэжээ.

Эх сурвалж: [Lord Keynes Pays a Visit](#)

ӨЛЗИЙТ СУЛТАН ХААНЫ МӨНГӨН ЗООС



БАГДАД ХОТ

1304-1316 он

Жин: 4.3 гр

Голч: 2.4 см

Нүүр тал: "Аугаа Их Өлзийт султан" гэж арабаар бичсэн.

Ар тал: "Аллахаас өөр бурхан үгүй. Мухаммед бол Аллахын элч" гэж арабаар бичсэн.





Ж.САЙНХИШИГ: ТӨВ БАНКНЫ ХАРААТ БУС БАЙДЛЫГ ҮНДСЭН ХУУЛИАР БАТАЛГААЖУУЛАХ ШААРДЛАГА, ҮНДЭСЛЭЛ БИЙ

Хуульч, судлаач Ж.Сайнхишигтэй ярилцлаа.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧӨӨС ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙН ТӨСӨЛД ТӨВ БАНКНЫ ХАРААТ БУСААР АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, БАТАЛГААГ БҮРДҮҮЛЭХ ЗОРИЛГОТОЙ ЗААЛТ ОРУУЛЖЭЭ. ЭНЭ ТӨСӨЛД ТА ЯМАР БАЙР СУУРЬТАЙ БАЙНА?

Юун түрүүнд Монголбанкны хараат бус байдлыг Үндсэн хуулиар зохицуулах шаардлага үүссэн үү үгүй юу гэдгийг тодорхойлох шаардлагатай байх. Төв банкны хараат бус байдлын хууль зүйн баталгааг аваад үзвэл хэд хэдэн асуудал байгаа.

Нэгд, төв банкны үндсэн зорилт нь юу юм бэ, үнийн тогтвортой байдлыг хангах чиг үүргийг хараат бусаар хэрэгжүүлэх гэж үздэг. Гэтэл манайд УИХ-ын даалгасан ажлыг гүйцэтгэх тал руу заримдаа явдаг гэж шүүмжилдэг. УИХ-аас томилогддог учраас хууль тогтоох байгууллага тогтоол шийдвэр гаргаад ирэхээр тэрийг нь биелүүлэхээс өөр аргагүй болдог болов уу. Тэгэхээр энд ямар ажил хийхийг нь зааглаж өгөхгүй бол янз бүрийн ажил хийдэг байгууллага болох вий, тэр нь эргээд мөнгөний үнэ цэнэд нөлөөлөх вий гэдэг асуудал байгаа. Үүнийг хуулиар зөв зохицуулах гээд чадахгүй байгаа гэж ойлгосон.

Дараагийн асуудал нь, Төв банк гаргах ёстой шийдвэрээ бие дааж гаргах эрх зүйн орчин бүрдсэн үү гэдэг. Одоогийн

Үндсэн хуулийн зохицуулалт болох 25.1.7 дахь заалтад төрийн мөнгөний бодлогыг тодорхойлох бүрэн эрхийг УИХ хэрэгжүүлэхээр заасан байгаа. Энд буй "төрийн мөнгөний бодлогыг тодорхойлох" гэдгийг мөнгөний бодлоготой холбоотой хууль тогтоомж баталж, түүнийг хэрэгжүүлэх үүрэг гэж үзэх үү, эсхүл мөнгөний бодлогын үндсэн чиглэлийг батлах гэж үзэх үү гээд судлаачид байр сууриа илэрхийлдэг. Практикт хоёр дахь чиглэлээр нь авч хэрэглэж байгаа. Өөрөөр хэлбэл мөнгөний бодлогын үндсэн чиглэлийг УИХ баталдаг. Мөнгөний бодлогын үр нөлөө урт хугацаандаа гардаг учраас заавал нэг жил байх албагүй. Энэ асуудлыг тодотгох шаардлагатай. Мөн УИХ-аар тухайлан үндсэн чиглэл баталж явж байгаа нь Монголбанкны чиг

үүргээ хэрэгжүүлэхэд тодорхой хэмжээгээр нөлөөлж байна. Энэ бол Үндсэн хуульд заасан Үндсэн хуулийн эрх зүйн асуудал байгаа.

Гуравт, Монголбанкны Ерөнхийлөгч, удирдлагуудыг улс төрийн шахалтаар бүрэн эрхийн хугацаанаас нь өмнө чөлөөлдөг асуудал бий. Хуульд 6 жилийн ажиллах бүрэн эрхийн хугацаатай боловч 1991-2016 оны хооронд Монголбанкны Ерөнхийлөгч нийт 7 удаа томилогдож, бүрэн эрхийн дундаж хугацаа 3.7 жил гэсэн судалгаа байгаа нь томилгоонд нөлөөлөл орж байна гэсэн үг. Ойрын хугацаанд улс төрийн нөлөөлөл гэдэг энэ асуудал шийдэгдэхгүй байх.

Эндээс үзэхэд мөнгөний бодлого, төв банкны гол гол хууль зүйн баталгааны зохицуулалт, хэрэгжилт манай улсад эргэж харах шаардлагатай байгаа. Дэлхийн 200 орчим улсын тал нь Төв банкныхаа хараат бус байдлыг Үндсэн хуулиараа зохицуулж байна. Мөн зорилтыг нь Үндсэн хуулиараа зохицуулсан сайн туршлага

бий. Тиймээс Монгол Улсын Төв банкны эрх зүйн баталгааг хангахын тулд Үндсэн хуулийн төвшинд авч үзэх шаардлагатай гэж би харж байгаа.

ТЭГВЭЛ ОДООГИЙН ӨРГӨН БАРИГДСАН ТӨСӨЛД ЭДГЭЭР АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭЖ ЧАДАХ УУ?

-Төсөлд Төв банкны хараат бус байдлыг хангах зорилготой зохицуулалт оруулж байгаа нь сайшаалтай сайн хэрэг.

Зохицуулалтын хувьд зарим нэг тодруулмаар зүйл харагдсан. Жишээ нь төсөлд “Монголбанк нь төрийн мөнгөний бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх ...” чиг үүргийг гүйцэтгэхээр тусгасан байгаа. Тэгэхээр түрүүн ярьсан мөнгөний бодлогыг батлах бүрэн эрх нь УИХ-д хадгалагдахаар хэвээр байна энэ төслөөр. Үүнийг Төв банк, түүний бүтцийн байгууллага буюу Мөнгөний бодлогын зөвлөл батлахаар оруулж өгвөл агуулгын шинжтэй өөрчлөлт болох болов уу.

Төв банкны эрх зүйн баталгааг хангах гол механизм нь түүний шийдвэр гаргах бүрэн эрхийн хараат бус байдлыг хангах асуудал юм. Өөрөөр хэлбэл, хууль зүйн хувьд мөнгөний бодлогыг тодорхойлох бүрэн эрх төв банкинд байхгүй тул төв банк үнийн тогтвортой байдлыг хангах үндсэн зорилтоо үр нөлөөтэй хэрэгжүүлэх эрх зүйн орчин манай улсад бүрдээгүй байна.

Хоёрт, төсөлд Монголбанкны удирдлагын томилгоо, бүрэн эрхийн хугацааны баталгааг тухайлан заагаагүй байгаа. Үндсэн хуулиар тодорхой хугацаагаар томилогдсон албан тушаалтныг хугацаанаас нь өмнө зүй бусаар чөлөөлөх боломжгүй бөгөөд зөвхөн хуульд заасан тодорхой үндэслэл бүрдсэн үед л чөлөөлөх боломжтой. Иймээс Төв банкны ерөнхийлөгчийн томилох, чөлөөлөх асуудлыг Үндсэн хуулиар зохицуулж, түүнийг үндсэн хуулийн эрх зүйн субъект болгосноор түүний хараат бус байдал, хариуцлагатай байдлын хууль зүйн баталгааг дээшлүүлэх

юм.

Төв банкны ерөнхийлөгч үндсэн хуульд заасан баталгааны хүрээнд чиг үүргээ бусдаас хараат бусаар явуулах нөхцөлийг хангаж өгөхийн зэрэгцээ тэр хэмжээний хариуцлагыг тус байгууллагаас шаардаж болох юм.

Тэгэхлээр мөнгөний бодлоготой холбоотой энэ удаагийн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн гол агуулга нь мөнгөний бодлогыг тодорхойлох бүрэн эрхийг төв банк хэрэгжүүлэх, төв банкны зорилт, бүтэц, удирдлагын бүрэн эрхийн, томилгооны журмыг Үндсэн хуулиар зохицуулж, УИХ хууль тогтоомж гаргах, удирдлагаас асуулга тайлан авах хэлбэрээр мөнгөний бодлогын хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх чиглэлд хандвал илүү үр нөлөөтэй болов уу.

ЕР НЬ ТӨВ БАНКНЫ ХАРААТ БУС БАЙДЛЫГ ҮНДСЭН ХУУЛИАР ЗОХИЦУУЛАХ ЧИГЛЭЛД ГАДААД УЛСЫН ТУРШЛАГА ЯМАР БАЙДАГ ВЭ?

Дэлхийн 200 орчим улсын тал нь Төв банкныхаа хараат бус байдлыг Үндсэн хуулиараа зохицуулж байгааг түрүүн хэлсэн.

Жишээ нь хойд хөрш ОХУ-ын Үндсэн хуулийн (1993) 75.2-т “Рублийн тогтвортой байдлыг хангаж, хамгаалах нь ОХУ-ын төв банкны үндсэн чиг үүрэг болно, банк нь энэ чиг үүргээ гүйцэтгэхдээ төрийн бусад байгууллагаас хараат бус байна.”, Эстони улсын Үндсэн хуулийн (1992) 111 дүгээр зүйлд “... Эстонийн банк нь ... үндэсний



Төсөлд Төв банкны хараат бус байдлыг хангах зорилготой зохицуулалт оруулж байгаа нь сайшаалтай сайн хэрэг. Зохицуулалтын хувьд зарим нэг тодруулмаар зүйл харагдсан. Жишээ нь төсөлд “Монголбанк нь төрийн мөнгөний бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх ...” чиг үүргийг гүйцэтгэхээр тусгасан байгаа.

мөнгөн тэмдэгтийн тогтвортой байдлыг хангана гэх зэргээр үндсэн зорилтыг нь зааж өгсөн байдаг.

Шийдвэр гаргах эрхийн хувьд Польш зэрэг улсад төв банкныхаа мөнгөний бодлого тодорхойлох, шийдвэр гаргах бүрэн эрхийг үндсэн хуульдаа тусгайлан зааж өгсөн. Төв банкны бүтэц, удирдлагын бүрэн эрхийн хугацаа, томилгооны харилцаа үндсэн хуульд түгээмэл зохицуулах хандлага байгаа. Тухайлбал, Армени, Албани, Чех, Эстони, Унгар, Литва, Словак улсыг энд дурдаж болно.

Ер нь манай улстай адил нийгэм эдийн засгийн шилжилт хийж буй, мөн Европын холбоонд нэгдэн орох шаардлагыг хангаж буй пост социалист улсуудын үндсэн хуульд төв банкны хараат бус байдлыг Үндсэн хуулиар дэлгэрэнгүй зохицуулах хандлагатай байна.

Харин хөгжингүй орнуудын Үндсэн хуульд тухайн улсын төв банкны статус, удирдлагын томилгооны асуудал зэрэг харьцангуй товч зохицуулалт байна. Тухайлбал, ХБНГУ, Финланд, Норвег, Швейцар, Швед зэрэг улс энэ ангилалд багтахар байна.

Дэлхийн улсуудын төв банкны талаарх үндсэн хуулийн зохицуулалтад төв банкны статус, бүтэц, хараат бус байдал, органик хуулиар бусад харилцааг зохицуулах асуудал, мөн төв банкны зорилго, мөнгөний бодлогын зорилт, засгийн газарт зээл олгохыг хориглох, удирдлагыг томилох, чөлөөлөх, ажлаа тайлагнах субъект зэрэг харилцааг хамарч байна.

ТӨВ БАНКНЫ ХАРААТ БУС БАЙДЛЫГ ҮНДСЭН ХУУЛИАР ЗОХИЦУУЛСНЫ АЧ ХОЛБОГДЛЫГ ЮУ ГЭЖ ҮЗЭЖ БАЙНА ВЭ?

Төв банк нь үндсэн хуулийн эрх зүйн харилцааны субъект болсон тохиолдолд түүний шийдвэр, үйл ажиллагаа мөн Үндсэн хуулийн шүүхийн хяналтад орох юм. Энэ нь тус институцийн хараат бус, хариуцлагатай байдлын түвшнийг дээшлүүлж, улс төрөөс хараат бусаар шийдвэр гаргах нөхцөлийг бүрдүүлэх үндсэн шийдэл байхыг үгүйсгэхгүй.

Ярилцсанд баярлалаа.

**ТҮҮХИЙ ЭДИЙН ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭ
(АМ.ДОЛЛАРААР, 29/VII ӨДРИЙН БАЙДЛААР)**



ТӨВ БАНКНЫ ХАРААТ БУС БАЙДАЛ: ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА, МОНГОЛБАНКНЫ АНХААРАХ АСУУДЛУУД

Б.Түмэнцэнгэл¹, Н.Ургамалсүвд², Г.Ганчимэг³

Судалгааны ажлын тойм, хураануй

I. ТӨВ БАНКУУДЫН ТОВЧ ТҮҮХ: ХАРААТ БУС ТӨВ БАНК БИЙ БОЛСОН НЬ

Төв банк улстөрийн нөлөөнөөс ангид, технократуудаас бүрдсэн мэргэжлийн байгууллага байх ёстой гэдэг үзэл тодорхой түүхийн замыг туулсны үр дүнд олон улсад нийтлэг жишиг болон тогтжээ. Дэлхийд төв банкуудын анхны суурь тавигдсан XVII зуунаас одоог хүртэлх түүхэн хугацаанд төв банкны хараат бус байдал хэрхэн хувьсан өөрчлөгдөж ирснийг дараах 3 үе шатанд хуваан авч үзэж болно. Үүнд, (i) Хараат бус, хувийн эзэмшлийн төв банкуудын үе, (ii) Засгийн газраас хараат, улсын өмчит төв банкуудын үе, (iii) Төв банкууд Засгийн газраас хараат бус, бие даасан төрийн институци болж хөгжсөн үе зэрэг үе шатууд багтана.

Хараат бус, хувийн эзэмшлийн банкууд: XVII зуун-XIX зууны эхэн үе

Дэлхийн анхны төв банк гэгддэг Рикс банк (Швед) 1668 онд үндэслэгдсэн бол орчин үеийн төв банкны суурь загвар болох Английн төв банк 1694 онд үүсгэн байгуулагдсан байдаг. XVII, XVIII зууны Европын сэргэн мандалт, аж үйлдвэрийн хувьсгалын нөлөөгөөр нийгэм эдийн засаг хурдтай шинэчлэгдэж, банк санхүүгийн системийн ач холбогдол, эдийн засагт гүйцэтгэх үүрэг эрс нэмэгдсэн тул Европын бусад орнуудад банк санхүүгийн систем эрчимтэй хөгжиж, одоогийн төв банкуудын суурь тавигджээ. Анхны төв банкууд өмчлөлийн хувьд хувийн эзэмшлийн банкууд байсан бөгөөд, Засгийн газарт зээл олгох, төлбөр тооцоог гүйцэтгэх, үнэт цаас буюу мөнгөн дэвсгэрт гүйлгээнд гаргах зэрэг чиг үүргийг гүйцэтгэх нь нийтлэг байв. Мөн банкны хямрал түгээмэл байсан учраас эцсийн зээлдэгчийн үүргийг гүйцэтгэх замаар банкинд итгэх итгэлийг хадгалах, эдийн засаг тогтвортой байлгах үүрэг функц нь хөгжиж эхэлсэн байна.

Засгийн газраас хараат, улсын өмчит банкууд: 1930-аад он - 1990 он

Цаг хугацааны явцад төв банкууд хувьсан өөрчлөгдсөөр XX зууны эхэнд “шилжилтийн” гэж нэрлэгддэг үетэй золгожээ (Bordo, 2007). Мөнгөний

зориулалтаар ашиглагдаж байсан олон төрлийн хэрэгслийг нэгтгэж мөнгөн дэвсгэртэд итгэх итгэлийг бий болгох, алтны стандартыг мөрдөж мөнгөн тэмдэгийн ханшийг тогтвортой байлгах, банкны хямралын үед тогтвортой байдлыг ханган эцсийн зээлдэгчийн үүргийг гүйцэтгэх зэрэг нь тухайн үеийн төв банкуудын гол үүрэг болоод байв. Харин Дэлхийн I дайны дараагаас, ялангуяа 1930-аад оны Их хямралын дараа ажил эрхлэлтийн түвшин, эдийн засгийн идэвхжил, болон үнийн түвшний тогтвортой байдал /гиперинфляци болон дефляциас сэргийлэх/ зэрэг макро эдийн засгийн асуудлууд чухал болсон байна. Энэ үеэс мөнгөн тэмдэгт гүйлгээнд гаргах, мөнгөний нийлүүлэлтийг удирдах, үнэ ханшийн бодлого хэрэгжүүлэх, банк санхүүгийн тогтвортой байдал болон макро эдийн засгийн тогтвортой байдлын асуудлуудыг төрөөс зохицуулах нь зүйтэй гэдэг үзэл дэлгэрэх болов. Улмаар гол банкуудыг нийгэмчилж, төрийн мэдлийн институци болгох үйл явц улс орнуудад өрнөсөн байна. Тухайлбал, Их хямралын дараагаар Холбооны нөөцийн банк (ХНБ)-ны бүтцийг өөрчилж 1935 оны гэхэд АНУ-ын Сангийн яамны харъяа болгосон бол Италийн төв банкныг 1936 онд, Францын төв банкныг 1946 онд нийгэмчилж төрийн мэдлийн институци болгосон байна.

Хараат бус, бие даасан төрийн институци: 1990 - одоо

Төв банкууд төрийн институци болж, Засгийн газрын харьяанд үйл ажиллагаа явуулж эхэлснээр олон улс оронд өндөр инфляци асуудал үүсгэх болжээ. Тухайлбал, Британид инфляци 1960-аад оны сүүлийн хагасаас өсч 1970-аад онд 20% давж байсан бол АНУ-д инфляцийн түвшин 1970-79 хооронд 3%-аас 12% хүрч нэмэгдэхийн зэрэгцээ инфляцийн ирээдүйн хүлээлт тогтворгүй болоод байв. Энэ үед ажилгүйдлийн түвшин өндөр, эдийн засгийн өсөлт маш бага байсан нь нийгэмд сөрөг үр дагаврыг бий болгож байлаа. Төв банкууд Засгийн газрын харьяанд байх үед улстөрчдийн нөлөөгөөр мөнгөний нийлүүлэлтийг хэт ихэсгэснээр стагфляци (өндөр инфляци, нам өсөлт) гэдэг үзэгдэлтэй нүүр тулахаас гадна мөнгөн тэмдэгийн

¹ Монголбанкны Мөнгөний бодлогын газар, Эдийн засгийн шинжилгээ, бодлогын хэлтсийн захирал

² Монголбанкны Мөнгөний бодлогын газар, Мөнгөний бодлого, төсөөллийн хэлтсийн захирал

³ Монголбанкны Мөнгөний бодлогын газар, Эдийн засгийн шинжилгээ бодлогын хэлтсийн эдийн засагч

хямрал, эдийн засгийн хямралтай тулгарсан тохиолдол Латин Америкийн хөгжиж буй орнууд дунд ч цөөнгүй байв. Ажлын байрыг нэмэгдүүлэх, эдийн засгийн идэвхжлийг дэмжих зорилгоор нийлүүлсэн мөнгө инфляцийг өдөөж, эдийн засгийн тогтворгүй байдалд хүргэснээр Төв банкны үүрэг ролийн талаар дахин авч үзэх шаардлага тулгарчээ.

Түүхийн эдгээр сургамжаас улбаалаад “Инфляци нам дор бөгөөд тогтвортой байх нь чухал бөгөөд үүний тулд төв банк хөндлөнгийн нөлөөнөөс хараат бус мөнгөний бодлого хэрэгжүүлэх ёстой” гэдэг зарчим олон улс оронд нийгмийн зөвшилцөл болж тогтжээ. Улмаар хараат бус төв банкны ач холбогдол, эдийн засагт үзүүлэх нөлөөний талаарх онолын үндэслэлүүд боловсруулагдахын зэрэгцээ зарим амжилттай улс орнуудын бодит туршлага бодлого боловсруулагч нарын анхаарлыг татах болсон байна. Тухайлбал, Германы төв банк /Бундесбанк/ харьцангуй эрт буюу 1957 оноос Засгийн газраас хараат бус мөнгөний бодлого хэрэгжүүлснээр өндөр инфляцитай тулгараагүй жишээг нэрлэж болох юм. Иймд төв банкийг улстөрийн нөлөөнөөс хараат бус болгох хандлага 1990-ээд оноос эрчимтэй өрнөсөн бөгөөд Шинэ Зеланд, Чех, Канад тэргүүтэй улс орнуудад хараат бус төв банк инфляцийг онилох бодлого хэрэгжүүлснээр инфляци нам дор түвшинд орсон нь судлаачид болон бодлого боловсруулагч нарын анхаарлыг ихээр татах болов. Үргэлжлээд 1997 онд Английн төв банкны Засгийн газраас хараат бус бодлого хэрэгжүүлэх эрхийг хуулиар баталгаажуулж, 1999 онд Европын төв банкийг үүсгэн байгуулахдаа анхнаас нь хараат бус байдлыг нь олон улсын гэрээ /Маастрихтийн гэрээ/гээр хангаж өгсөн байдаг. Бусад улс орнуудад ч төв банк хараат бус байх ёстой гэдэг энэхүү үзэл эрчээ авснаар 2010 он гэхэд дэлхийн 120 орчим улс орнууд ямар нэгэн байдлаар хуулиндаа төв банкны хараат бус байдлыг тусгаж өгчээ.

II. ТӨВ БАНКНЫ ХАРААТ БУС БАЙДАЛ: ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ

Төв банкны хараат бус байдлын үндсэн элементүүд

2008-09 оны санхүүгийн хямралаас хойш олон улсад төв банкууд мөнгөний бодлогоос гадна санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилгыг хэрэгжүүлэх нь түгээмэл болсноор “төв банкны хараат бус байдал” гэдэг ойлголтын агуулга, цар хүрээ тэлж байна. Гэхдээ санхүүгийн тогтвортой байдал болон төв банкны хараат бус байдлын хоорондох хамаарлын талаар бодлого боловсруулагч нар ч, судлаач эрдэмтэд ч нэгдсэн байр сууринд хүрээгүй зүйлс олон бий. Иймд энэхүү ажилд

төв банкны хараат бус байдлыг мөнгөний бодлогын хараат бус байдлын хүрээнд авч үзлээ. Энэ сэдвээр хийгдсэн судалгааны ажлууд болон улс орнуудын төв банкны удирдлагуудын илтгэлд хараат бус төв банк гэдэг ойлголтын хүрээнд i) зорилгын хараат бус байдал, ii) хэрэгслийн хараат бус байдал, iii) үйл ажиллагааны хараат бус байдал гэдэг 3 ойлголтыг хамрах нь түгээмэл байна.

Нэгдүгээрт, зорилгын хараат бус байдал буюу төв банкны мөнгөний бодлогын үндсэн зорилтыг хэн хэрхэн тодорхойлох вэ гэдэг нь төв банкны хараат бус байдлыг хэмжих нэг үндсэн үзүүлэлт болдог. Төв банк зорилгын хувьд хараат байх нь зохимжтой бөгөөд, зорилгыг аль болох тодорхой, нарийвчилж тогтоож өгөх нь зүйтэй гэж үздэг (Fischer, 2015).

Төв банк зорилгоо өөрөө тодорхойлбол ёс зүйн гажуудал /moral hazard/ үүсэх эрсдэлтэй тул нийгмийн сайн сайхан байдалд хамгийн нийцтэй зорилгыг хөндлөнгөөс тогтоож өгснөөр уг эрсдэлээс сэргийлэх боломжтой юм. Иймээс мөнгөний бодлогын зорилтыг хууль тогтоогч байгууллага эсвэл гүйцэтгэх засаглалаас тогтоодог жишиг олон улсад түгээмэл байна. Тухайлбал Английн төв банкны инфляцийн зорилтыг Засгийн газраас тогтоож өгдөг бол Америкийн төв банкны хувьд, Конгресс буюу хууль тогтоох байгууллагаас тогтоож өгдөг.

Мөнгөний бодлогын зорилгын тоо олон эсхүл нь эрсдэлүүдийг үүсгэдэг. Тухайлбал, зорилгууд өөр хоорондоо зөрчилдсөнөөр дунд урт хугацаанд алийг нь ч биелүүлж чадахгүйд хүрэх эрсдэлтэй бөгөөд, төв банкны мөнгөний бодлого олон зорилготой улс орнуудын эдийн засгийн гүйцэтгэл сайнгүй, нэг хүнд ногдох ДНБ-ийн өсөлт бага байх хандлага ажиглагддаг (BIS, 2009). Үүнээс гадна, олон нийтээс сонгогддоггүй субъектэд олон зорилгыг ногдуулж, их эрх мэдлийг төвлөрүүлэх нь ардчилсан нийгмийн суурь зарчимд нийцтэй бус гэж үзэх үндэслэл ч бий.

Төв банкны зорилго тодорхой бус байх үед хариуцлага тооцоход төвөгтэй болж ёс зүйн гажуудал үүсэх, төв банкны олон нийттэй харилцах харилцаа төвөгтэй болох зэрэг эрсдэл үүсдэг.

Эдгээр үндэслэлээр мөнгөний бодлогын зорилгыг хязгаарлагдмал хүрээнд нарийвчлан тодорхойлох нь оновчтой гэж үзэж төв банкууд үндсэн зорилгоо “үнийн тогтвортой байдал” хэмээн тодорхойлох чиг хандлага 1990-ээд оноос эрчимжжээ. Тухайлбал, 2000 онд 94 орны төв банкийг оролцуулсан судалгаанд 85 төв банк зорилгоо ийнхүү томъёолсон байв (Mahadeva & Sterne, 2000). Үнийн тогтвортой байдлыг хангах нь төв банк

мөнгөний бодлогоор дамжуулж эдийн засагтаа оруулах хамгийн том хувь нэмэр гэдэг үзэл баримтлал олон улсад нийтлэг жишиг болж байна.

Хоёрдугаарт, хэрэгслийн хараат бус байдал буюу зорилгоо хэрхэн биелүүлэх вэ гэдэг нь төв банкны хараат бус байдлыг тодорхойлох дараагийн нэг чухал үзүүлэлт юм. Үүний хүрээнд мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх инструментийн сонголтоос гадна төв банкны засаглалын тогтолцоо, мөнгөний бодлогын шийдвэр гаргах процесс багтах бөгөөд эдгээр нь хөндлөнгийн нөлөөгүй байх нь оновчтой буюу “төв банк арга хэрэгслийн хувьд хараат бус байх нь зүйтэй” гэж үздэг (Debelle & Fischer, 1994).

Гуравдугаарт, үйл ажиллагааны хараат бус байдлын хүрээнд төв банкны санхүүгийн байдал; шийдвэр гаргагчдын томилгоо болон албан тушаалаас чөлөөлөх асуудал; цалин хөлсийг тогтоох арга барил зэрэг нь төв банкны хараат бус байдлын чухал элемент болдог.

Төв банкны ил тод байдал

Төв банкны хараат бус байдлын дунд урт хугацааны баталгаа нь олон нийтийн итгэл, хараат бус төв банкны талаарх үнэлэмж юм. Төв банк олон нийтийн өмнө хариуцлагатай ажиллаж, мөнгөний бодлогод итгэх итгэлийг хадгалж, хараат бус байдлаа тогтвортой баталгаатай байлгахын тулд үйл ажиллагаа, бодлогын шийдвэрээ нээлттэй ил тод байлгах зайлшгүй шаардлагатай. Хараат бус төв банк хаалттай байх нь ардчилсан нийгмийн суурь зарчимд нийцэхгүйгээс гадна, олон нийтийн өмнө үл итгэх байдлыг бий болгож хараат бус байдлаа эмзэг болгох эрсдэлийг үүсгэнэ. Тийм ч учраас өнөөгийн төв банкууд ил тод байдлыг эрхэмлэж жилийн тайлан, санхүүгийн аудитлагдсан тайлан, бодлогын шийдвэрүүдийн үндэслэлийг тайлбарласан мэдэгдэл, хэвлэлийн хурлууд, инфляцийн тайлан гэх мэт олон нийттэй харилцах хэрэгсэл, сувгуудаар дамжуулж нээлттэй ил тод байдлаа хангаж ажиллахыг зорьж байна. Хараат бус байдлын индексээс гадна, ил тод байдлын индексээр өндөр үзүүлэлттэй төв банкуудтай орнуудад инфляцийг нам бөгөөд тогтвортой байлгах зорилт илүү амжилттай биелсэн байдаг (Cukierman, 2006).

IV. ТӨВ БАНКНЫ ХАРААТ БУС БАЙДАЛ: МОНГОЛБАНКНЫ АНХААРАХ АСУУДЛУУД

Төв банкны хараат бус байдал өндөр байх нь эдийн засгийн үзүүлэлтүүд, тэр дундаа мөнгөний бодлогын үндсэн зорилт болох үнийн тогтвортой байдал дунд урт хугацаанд хангагдахад эерэгээр нөлөөлдөг бөгөөд хараат бус байдлыг зорилгын хараат бус байдал, хэрэгслийн хараат бус байдал, үйл ажиллагааны хараат

бус байдал зэргээр 3 ерөнхий бүлэгт хувааж болохыг өмнөх хэсгүүдэд тоймлосон. Энэ хэсэгт төв банкны хараат бус байдлын хүрээнд Монголбанкны хувьд цаашид анхаарч сайжруулах шаардлагатай асуудлуудыг авч үзэж, зарим боломжит шийдлийг дэвшүүлээ.

Зорилтын хараат бус байдлын хүрээнд

1. Монголбанкны үндсэн зорилтыг олон улсын жишигт нийцүүлэх: Дунд хугацааны үнийн тогтвортой байдлыг хангах

Монголбанкны үндсэн зорилт салаа утгыг илэрхийлж байгаа нь олон нийтийн дунд буруу хүлээлтийг үүсгэх, Төв банкны олон нийттэй харилцах харилцааг төвөгтэй болгох зэрэг эрсдэлийг үүсгэж, улмаар Төв банкны хараат бус байдалд эрсдэл учруулж байгаа тул үндсэн зорилтыг нарийвчлан тодорхойлох, олон улсын жишигт нийцүүлэх шаардлагатай. Төв банкны тухай хуулийн 4.1-т “Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгийн тогтвортой байдлыг хангахад оршино” гэж заасан байдаг нь нэг талаас төгрөгийн худалдан авах чадварын тогтвортой байдал буюу дотоод үнийн тогтвортой байдал, нөгөө талаас төгрөгийн гадаад валюттай харьцах үнийн тогтвортой байдал буюу төгрөгийн ханшийн тогтвортой байдал гэж ойлгогддог.

Хэдийгээр i) Төв банкны тухай хуулийн 22.2-т “Монголбанк гадаад валюттай харьцах төгрөгийн ханшны бодлогыг тодорхойлж, хэрэгжүүлэхдээ ханш нь чөлөөтэй бөгөөд бодитой байх...” хэмээн томъёолсон нь ханшийн уян хатан байдлыг илэрхийлэхийн зэрэгцээ ii) Монголбанк жил бүр Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлийг УИХ-д өргөн барихдаа мөнгөний бодлогын үндсэн зорилтыг хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх жилийн инфляцийн тодорхой түвшнээр тодорхойлдог боловч олон нийтийн дунд “Төгрөгийн ханшийг тогтмол байлгах нь Монголбанкны үүрэг” гэсэн буруу ойлголт түгээмэл байсаар ирсэн. Энэхүү салаа утга Төв банк хоёр зорилгын дунд хэр хариуцлагатай бодлого хэрэгжүүлснийг хэмжихэд тодорхой бус байдал үүсгэдэг. Мөн үндсэн зорилт төгрөгийн ханш хэмээн ойлгогдож байгаа нь мөнгөний бодлогын арга хэрэгслээр бүрэн удирдах боломжгүй үүргийг ногдуулах, улмаар Төв банкны хараат бус байдалд эрсдэл учруулсаар ирсэн байна.

Төв банкны үндсэн зорилтыг “үнийн тогтвортой байдал” хэмээн олон улсын жишигт нийцүүлснээр Монголбанк төгрөгийн гадаад валюттай харилцах ханшийг огт анхаарахгүй болно гэсэн үг биш юм. Нэг талаас, Монгол улсад хэрэглээний сагсны 40% нь импортын бараа бүтээгдэхүүнээс хамааралтай


тул инфляци тогтвортой байхад ханшийн тогтвортой байдал чухал юм. Иймд ханшийн огцом хэлбэлзлийг зөөлрүүлэхэд чиглэсэн бодлогын одоогийн арга хэмжээ нь Төв банк үнийн тогтвортой байдлыг хангах зорилгын хүрээнд хэвээр хадгалагдах болно. Харин Монголбанкны үндсэн зорилтыг салаа утгагүй, олон улсын жишигт нийцүүлэн илүү нарийсган тодорхойлж өгснөөр Монголбанк үндсэн зорилттой нийцтэй бус бодлого үйл ажиллагааг хэрэгжүүлэх эрсдэлийг хязгаарлаж, илүү хариуцлагатай бодлого хэрэгжүүлэх хөшүүрэг болох болно.

2. Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлийг жил болгон шинэчилж батлах нь оновчтой бус

Монгол Улсын Үндсэн хуулийн 25.1.7, Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 10.2-т жил бүр төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлийг УИХ батлахаар заасан байдаг. Гэвч мөнгөний бодлогыг томъёолох, хэрэгжүүлэх сайн жишгээс зөрүүтэй эдгээр хуулийн заалт нь үр дүнтэй мөнгөний бодлого хэрэгжих нөхцөлийг хязгаарлах, Төв банкны үйл ажиллагааны бие даасан байдалд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэл үүсгэж зарим тохиолдолд эрсдэл бодитоор биелэх тохиолдол ч байв. Монголбанк Төв банкны тухай хуулиар тодорхойлсон зорилтыг хангахад чиглэн ажиллаж, биелэлтээ ил тодоор тайлагнаж байх үед жил бүр мөнгөний бодлогын зорилтыг хэлэлцэх, өөрчлөх шаардлагагүй юм.

Мөнгөний бодлогыг тодорхойлох, бодлогын үр нөлөөг тооцохдоо бусад төв банкууд ихэвчлэн гурван жилийн хугацаанд тооцож, хэмжиж байна. Гэтэл жил бүр Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлд тусгагдсан инфляцийн зорилтыг дийлэнхдээ гурваас цөөн жилээр УИХ-аас өөрчлөн тогтоож байв (Зураг 1). Мөнгөний бодлогын эцсийн үр дүн эдийн засагт бүрэн илрэхээс нь өмнө инфляцийн зорилтыг ийнхүү ойрхон давтамжтай өөрчлөх нь бодлогын нөлөөллийг бууруулах, дотоод гадаадын зах зээл дээр тодорхой бус байдал үүсгэх, бодлогын үр дүнг хэмжих боломжгүй болгох зэрэг хүндрэлүүдийг үүсгэж байв.

Зураг 1. Инфляцийн гүйцэтгэл ба зорилт: 1999-2018



Хэрэгслийн хараат бус байдал

- Хэрэгслийн сонголт: Төв банк зорилгын хувьд хараат, харин хэрэгслийн хувьд хараат бус байх нь эдийн засагт эерэг нөлөөтэй талаар өмнөх хэсэгт тайлбарласан. Монголбанкны хувьд мөнгөний бодлогод ашиглах арга хэрэгслийг Төв банкны тухай хуулийн 11.1 зүйлээр тодорхой зааж өгсөн байдаг. Энэ нь мөнгөний бодлогын үндсэн зорилтыг нарийвчлан тодорхойлоогүй, ТМБҮЧ-ийн хүрээнд УИХ-аас үүрэг даалгавар, чиглэл өгөх боломжтой одоогийн хууль эрх зүйн орчинд Төв банк үндсэн зорилтоосоо хазайсан үйл ажиллагаа эрхлэх эрсдэлийг хязгаарлах ач холбогдолтой.
- Бодлого боловсруулах, шийдвэр гаргах процессын сайжруулалт: Мөнгөний бодлого боловсруулж хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо судалгаа хийх хүний нөөцийн оновчтой бодлогыг хэрэгжүүлэхээс гадна шийдвэр гаргах процессыг үргэлжлүүлэн сайжруулах нь бодлогод итгэх итгэл, улмаар төв банкны хараат бус байдлыг баталгаажуулахад чухал хувь нэмэр болно. 2018 онд нэмэлт өөрчлөлт орсон Төв банкны тухай хуулийн нэг чухал шинэчлэл нь Мөнгөний бодлогын хороотой холбоотой хэсэг бөгөөд бодлогын шийдвэрийг хамтын зарчмаар гаргадаг сайн засаглалын элементийг Монголбанкинд нэвтрүүлсэн явдал байв.
- Макро зохистой бодлого ба төв банкны хараат бус байдал: Макро зохистой бодлого нь олон улсад ч харьцангуй шинэ зүйл бөгөөд зорилгын хэмжүүр, бодлогын шилжих механизм, институцийн хараат бус байдалтай холбоотой нэгдсэн дүгнэлт, нийтлэг жишиг хараахан тогтоогүй байна. Монголбанк 2018 оны Төв банкны тухай хуулийн шинэчлэлээр макро зохистой бодлогыг хэрэгжүүлэх мандаттай болж, уг бодлогыг нэвтрүүлэх стратегийн хүрээнд мөнгөний бодлоготой хослуулан хэрэгжүүлж буй. Цаашид бодлогыг хэрэгжүүлэх явцдаа олон улсын шилдэг туршлага болон дотоодод хэрэгжүүлсэн бодлогын шийдвэрийн үр дүн, туршлага дээрээ үндэслээд макро зохистой бодлогыг хэрэгжүүлэх тогтолцоог хөгжүүлэх шаардлагатай.

Үйл ажиллагааны хараат бус байдал

- Төв банкны санхүүгийн байдал: Монголбанк 2012-16 онд төсвийн шинжтэй үйл ажиллагааг

санхүүжүүлж, зээлээр гадаад валютын албан нөөцийг нэмэгдүүлсэн зэргээс голлон шалтгаалж алдагдал хурдтай нэмэгдсэн нь Төв банк, мөнгөний бодлогод итгэх итгэлийг бууруулах, цаашлаад төв банкны хараат бус байдлыг эмзэг байдалд оруулах эрсдэлийг үүсгэсээр байна. Иймд алдагдлыг оновчтой хувилбараар бууруулах бодлогыг баримтлах, ингэхдээ Төв банкны хараат бус байдалд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх нь чухлаар тавигдаж байна.

- Монголбанкны Ерөнхийлөгчийн томилгоо, албан тушаалаас чөлөөлөх асуудал: 1996 онд анх Төв банкны хууль батлагдсанаас хойш Монголбанкны Ерөнхийлөгч бүрэн эрхийн хугацаагаа дуусгаж ажилласан ганцхан тохиолдол байгаа нь Монголбанкны хараат бус байдал эмзэг явж ирсний нэг бодит илрэл юм. Хэдийгээр 2018 оны Төв банкны тухай хуулийн шинэчлэлээр Монголбанкны хараат бус байдлыг дээшлүүлэх алхмууд хийгдсэн ч бодит амьдрал дээр бүрэн туршигдаагүй байна. Монголбанкны удирдлагыг Төв банкны үндсэн зорилттой шууд холбоогүй шалтгаанаар албан тушаалаас чөлөөлөх эсхүл хуульд нийцгүй үндэслэлээр огцруулах боломжийг хаах шаардлагатай. Үүний тулд огцруулах саналын босгыг өндөрсгөхийн зэрэгцээ Төв банкны тухай хуульд заасан албан тушаалаас чөлөөлөх үндэслэл нь өөрөө Төв банкны хараат бус байдлыг бодитоор баталгаажуулах дархлаа болсон байх шаардлагатай. Төв банкны тухай хуулийн 26.6-д заасан Монголбанкны удирдлагуудыг албан тушаалаас нь чөлөөлөх үндэслэл дунд “үүрэг ажлаа хангалтгүй биелүүлсэн тохиолдолд” (26.6.4) гэж томъёолсон байгаа нь утга агуулгын хувьд тодорхой бус байна.
- Төв банкны удирдлагын цалин хөлс: Монголбанкны Ерөнхийлөгч нарын цалинг УИХ-аас тогтоож ирсэн жишиг нь хэд хэдэн эрсдэлийг үүсгэх магадлалтай. Улсын санхүүгийн зах зээл, макро эдийн засагт чухал үүрэгтэй институцийг удирдагч албан тушаалтны цалинг өрсөлдөхүйц түвшинд тогтоох нь ажил үүргээ үнэнч шударгаар гүйцэтгэх нэг чухал нөхцөл, хөшүүрэг байх болно. Мөн цалинг ямар дүрмээр хэрхэн тогтоохоос хамаарч албан тушаалтанд нөлөө үзүүлэх, хараат бусаар ажиллахад нь нөлөөлөх боломжийг нээлттэй үлдээж буй. Иймд Монголбанкны удирдлагуудын цалин

хөлсийг тогтоох тогтолцоог Төв банкны хараат бус байдалд эрсдэл учруулахгүй хэлбэрээр бүрдүүлэх нь чухал юм.

Ил тод байдал, олон нийттэй харилцах харилцаа ба санхүүгийн боловсрол

- Ил тод байдал, олон нийттэй харилцах харилцаа: 2017 оноос хойш Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлд олон нийттэй харилцах харилцааг сайжруулах талаарх заалтыг тусгаж Монголбанкны ил тод байдал, олон нийттэй харилцах харилцааг олон улсын шилдэг туршлагад нийцүүлэх алхмууд хийгдэж буй.⁴ Үүний хүрээнд олон нийттэй харилцах арга хэрэгслүүдийг сайжруулах, олон улсын төв банкуудын нийтлэг жишгийг нэвтрүүлэх, Монголбанкны ил тод байдал, олон нийттэй харилцах үйл ажиллагааг үнэлж, сайжруулалтуудыг хийх зэрэг ажлууд хийгдсэн байна. Төв банк олон нийттэй харилцах харилцаа нь зах зээл дээрх мэдээллийн тэгш бус байдлыг бууруулж эдийн засагт оролцогчдын хүлээлтийг үр дүнтэй удирдах, эдийн засагт тогтвортой байдлыг бий болгох ач холбогдолтой.
- Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэг боловсрол: Мөнгөний бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд зөвхөн санхүүгийн зах зээлийн гол институци оролцогчдоос гадна, эдийн засагт хөдөлмөр эрхэлж санхүүгийн шийдвэр гаргаж буй иргэдийн үйл хөдлөл хэр оновчтой байх вэ гэдэг нөлөөтэй. Эдийн засагт оролцогчдын санхүүгийн шийдвэр, үйл хөдлөл хэр оновчтой байх вэ гэдэг нь санхүү эдийн засгийн суурь мэдлэг боловсролоос тодорхой хэмжээнд хамаарах тул төв банкууд санхүүгийн боловсролд чухал ач холбогдол өгч, нийгмийн хариуцлагатай байдлын хүрээнд анхаардаг болсон. Үүний зэрэгцээ олон нийт төв банкны үйл ажиллагаа, хэрэгжүүлж буй бодлогыг ойлгох чадвар өндөр байх нь төв банкны хараат бус байдлыг чухал гэж үзэх нийгмийн зөвшилцөлд хүрч, төв банкны хараат бус байдалд чухал дэмжлэг болно.

БАНКНЫ САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙГ ХЭРХЭН ОЙЛГОХ ВЭ?

/Таны санхүүгийн мэдлэгт/

1. ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ХҮРЭЛЦЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТ

Зээлийн эрсдэл буюу олгосон зээл эргэж төлөгдөхгүй байх нь банкны санхүүгийн эрүүл мэндэд хүчтэй нөлөөлдөг, нэг гол эрсдэл юм. Эдийн засгийн ерөнхий байдал эсхүл тухайн зээлдэгчийн бизнесийн онцлогоос болоод зээл эргэж төлөгдөхөө байлаа ч харилцагч, хадгаламж эзэмшигчийн мөнгө бүрэн бүтэн байх ёстой. Энэ баталгааг хангахын тулд банкуудад тодорхой хэмжээний өөрийн хөрөнгөтэй байх шаардлагыг тавьдаг. Ингэснээр алдагдлыг банк өөрийн хөрөнгөөрөө хааж, харин харилцагч хадгаламж эзэмшигч хохирохгүй үлдэнэ гэсэн үг юм. Өөрийн хөрөнгийн хүрэлцээ нь тухайн банк хэр эрсдэл даах чадвартай вэ гэдгийг харуулах чухал үзүүлэлт болдог.

2. ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАРЫН ХАРЬЦАА ҮЗҮҮЛЭЛТ

Банк хуулиар харилцагчийн мөнгийг анхны шаардлагаар нь гаргаж өгөх үүрэгтэй байдаг. Үүнийг боломжтой байлгахын тулд банк хөрөнгийн тодорхой хэсгээ бэлэн мөнгө, бусад түргэн борлогдох буюу хөрвөх чадвар сайтай хөрөнгө хэлбэрээр бэлэн байлгах шаардлагатай. Үнэт металл, Засгийн газрын үнэт цаас, Төв банкны үнэт цаас зэрэг нь зах зээл дээр хурдан борлогдож, шууд бэлэн мөнгө болж хөрвөх чадвар өндөртэй байдаг. Харин зээл бол ихэвчлэн эргэн төлөгдөж байж л бэлэн мөнгө болох тул түргэн борлогдох зүйл биш юм. Тухайн банк хэр төлбөрийн чадвартай байна вэ гэдгийг энэ үзүүлэлт харуулна.

3. ЗЭЭЛИЙН ТӨВЛӨРЛИЙН ЭРСДЭЛИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА

"Бүх өндгөө нэг сагсанд хийх хэрэггүй" гэдэг зарчим банкуудын хувьд чухал. Зээл олгохдоо газарзүйн байрлаас эхлээд эдийн засгийн салбар, зээлдэгчээ аль болох төрөлжүүлэх нь зээлийн эргэн төлөлтөд учрах эрсдэлийг бага байлгах ач холбогдолтой.

Эдгээрээс ялангуяа нэг зээлдэгч, түүнтэй холбоотой этгээдэд их хэмжээний зээл олгох нь зээл эргэн төлөгдөхгүй байх тохиолдолд банкинд том эрсдэлийг үүсгэдэг тул зохицуулалтаар хязгаарлаж өгдөг.

4. ГАДААД ВАЛЮТЫН ХАНШИЙН ЭРСДЭЛИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА

Гадаад валютын эх үүсвэр татах, гадаад валютаар зээл олгох, эсвэл валютын арилжаа хийх нь арилжааны банкны өдөр тутмын бизнесийн үйл ажиллагааны нэг юм. Гэхдээ ханш өөрчлөгдөх үед валютын өглөг, авлага нь хоорондоо хэт зөрүүтэй бол эрсдэлийг үүсгэдэг тул зохицуулагчийн зүгээс зах зээлийн энэ эрсдэлийг бага байлгахын тулд дээд лимитийг тогтоож өгдөг. Гадаад валютын нээлттэй позиц буюу валютын өглөг авлагын зөрүү нь банкны өөрийн хөрөнгийн тодорхой түвшнээс хэтрэх ёсгүй бөгөөд, ингэснээр ханшийн зөрүүнээс үүсэх эрсдэлийг банк дааж чадна гэсэн үг юм.

5. ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ХАРЬЦАА

Банк харилцагч, хадгаламж эзэмшигчдээс татсан эх үүсвэрээрээ үл хөдлөх хөрөнгө худалдаж авах гм зээл олголт, санхүүгийн зуучлалд хамаарахгүй зүйл хийх нь зохимжгүй. Иймд зохицуулагчийн зүгээс банкинд эзэмшиж болох үндсэн хөрөнгө дээр нь дээд лимит тогтоож өгдөг.

Эдгээр шалгуур үзүүлэлтүүдийн зохих ёстой хэм хэмжээ, түүнийг хэрхэн хангаж ажиллаж буйг улирал тутам банкууд вебсайт дээрээ мэдээлдэг. Мөн санхүүгийн тайлангаа нийтэлдэг тул ер нь ямар хэмжээтэй банк вэ, бизнес нь хэр өсч байгаа, ашигт ажиллагаа нь хэр вэ, эрсдэл даах чадвар нь ямар түвшинд байна зэргийг үзэж болно. Үүний тулд активын хэмжээ, бүтэц болон өсөлт, чанаргүй зээл түүнд байгуулсан эрсдэлийн сан, цэвэр ашиг ба түүнийг нийт актив эсвэл өөрийн хөрөнгөд нь харьцуулсан харьцаа гэх мэт тухайн банкны санхүүгийн байдлыг илэрхийлэх энгийн үзүүлэлтүүд тус болно.



“Хүн нэг өмөө босоод л
санхүүгийн мэдлэгтэй болдоггүй”

Шон мэнди
(Дэлхийн банкны зөвлөх)




ТӨСӨВЧИН Аппликэйшн



Энэхүү аппликэйшн нь өөртөө хуримтлал тооцоологч,
хадгалагч, зээл тооцоологч, ипотека, төсөвлөгч зэрэг
тооцоолууруудыг багтаасан.

www.sankhuuginbolovsrol.mn



/Mongolbank.mn



/Санхүүгийн боловсрол



@mongolbank_mn



www.mongolbank.mn



/Mongolbankmn



info@mongolbank.mn



11 310081